**Гурванбулаг сумын ИТХ-ын Тэргүүлэгчид**

# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛДААНААС ГАРГАСАН ТОГТООЛЫН ЭМХТГЭЛ

**(2012-2015)**

**2015.11.01**

# БАЯНХОНГОР АЙМГИЙН ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫНХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2012 оны 12 сарын 06 өдөр Дугаар _1/1_ Хөвийн ам

Төлөөлөгчдийн бүрэн эрхийг
зөвшөөрөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Аймаг, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.8 дахь заалт, сонгуулийн хорооны дарга С.Алтанцэцэгийн төлөөлөгчдийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай тавьсан илтгэлийг хэлэлцээд сумын ИТХ-ын анхдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Сумын ИТХ-ын сонгуулийн 281, 282, 283, 284, 285-р хэсэг буюу 1, 2, 3, 4, 5-р тойргууд болон намын жагсаалтаар сумын ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдсон хавсралтад заасан нэр бүхий 21 төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчөөр сонгогдсон төлөөлөгчдөд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа нутан дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомж, бусад актуудыг мөрдлөг болгон ажиллахыг үүрэг болгосугай.

ХУРАЛДААНЫ ДАРГА Б.НАНСАЛМАА

Сумын ИТХ-ын ээлжит 1 дүгээр
хуралдааны 1/1 -р тогтоолын хавсралт

## СУМЫН ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН НЭРИЙН ЖАГСААЛТ

| Д/Д | Òîéðãèéí äóãààð | Òº ëº º ëº ã÷èéí î âî ãí ýð | Í àì ûí õàðúÿàëàë |
|---|---|---|---|
| 1 | 1-ð òîéðîã | Ч.Эрдэнэ-Очир | АН |
| 2 | | Г.Ууганбаяр | АН |
| 3 | | Ц.Баатаржав | МАН |
| 4 | 2-ð òîéðîã | Б.Баяндалай | Бие даагч |
| 5 | | Д.Баяржаргал | МАН |
| 6 | | Д.Энхээ | МАН |
| 7 | 3-ð òîéðîã | Д.Болд-Аюуш | МАН |
| 8 | | Л.Энэбиш | АН |
| 9 | | А.Хүрэлбаатар | МАН |
| 10 | 4-ð òîéðîã | Ч.Батсайхан | Бие даагч |
| 11 | | Ц.Энхболд | МАН |
| 12 | | Н.Оюумаа | МАН |
| 13 | 5-ð òîéðîã | Э.Жавхлан | АН |
| 14 | | Б.Нансалмаа | АН |
| 15 | Намын жагсаалтаар сонгогдсон төлөөлөгчид | Б.Пүрэвсэнгэ | МАН |
| 16 | | П.Түвшинтөгс | МАН |
| 17 | | Р.Ганболд | МАН |
| 18 | | Р.Цогт | МАН |
| 19 | | Д.Банзрагч | АН |
| 20 | | Д.Далай | АН |
| 21 | | Ж.Чулуунбат | АН |

**__________oOo_________**

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2012 оны 12 сарын 06 өдөр Дугаар _1/2_ Хөвийн ам

Хуралдааны дэг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.14 дэх заалтыг тус тус үндэслэн сумын ИТХын анхдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааны дэгийн төсөлд төлөөлөгчдийн гаргасан саналыг нэмж тусган хавсралтаар баталсугай.

Хоёр. Батлагдсан дэгээ мөрдөн ажиллахыг төлөөлөгчдөд, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг хуралдааны даргад үүрэг болгосугай.

ХУРАЛДААНЫ ДАРГА Б.НАНСАЛМАА

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2012 оны 12 сарын 06 өдөр | Дугаар _1/5_ | Хөвийн ам

Хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Õóðëûí òàñðàëòã¿é, áàéí ãûí ¿éë àæèëëàãààã õàí ãàx зорилгоор Õóðлын õóðàëäààí ààð õýëýëöýõ àñóóäëûã óðüä÷èëàí áýëòãýõ, ñàí àë, ä¿ãí ýëò ãàðãàõ, Õóðëûí òî ãòî î ë, øèéäâýðèéí áèåëýëòèéã õÿí àí øàëãàõ ÷èã ¿¿ðýã á¿õèé õî ðî î ã дараах чиглэлээр байгуулсугай. Үүнд:

1. Төсөв санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн хорооны даргаар төлөөлөгч Э.Жавхлан , гишүүд Р.Цогт, Ч.Эрдэнэ-Очир, А.Хүрэлбаатар, Р.Ганболд

2. Хөдөө аж ахуй, Байгаль орчины асуудал эрхэлсэн хорооны даргаар төлөөлөгч Д.Энхээ, гишүүд Г.Ууганбаяр, Б.Баяндалай, П.Түвшинтөгс, Л.Энэбиш

3. Төрийн болон төрийн бус байгууллагын асуудал эрхэлсэн хорооны даргаар төлөөлөгч , Ц.Энхболд гишүүд Н.Оюумаа, Ц.Баатаржав, Ч.Батсайхан, Б.Нансалмаа

4. Дэд бүтэц, жижиг дунд үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн хорооны даргаар төлөөлөгч Д.Баяржаргал, гишүүд Ж.Чулуунбат, Д.Банзрагч, Д.Далай, Д.Болд-Аюуш

Хоёр. Хороодын ажлын төлөвлөгөө, гишүүдийн ажил үүргийн хуваарийг гарган ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулж холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актуудыг чанд мөрдөн ажиллахыг хороодын дарга, гишүүдэд, хийсэн ажлын тайлангаа сумын ИТХ-ын хуралдаан, Тэрүүлэгчдийн хуралд тайлагнаж ажиллахыг хороодын дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА Б.ПҮРЭВСЭНГЭ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2012 оны 12 сарын 19 өдөр Дугаар _2/1_ Хөвийн ам

Сумын 2013 оны төсөв батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, аймгийн ИТХ-ын 2012 оны 2/4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Гурванбулаг сумын 2013 оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурдсанаар баталсугай.

/Мянган төгрөг/

| | |
|---|---|
| **Сумын төсвийн орлого бүгд** | **91350.0** |
| ***Нэг. Орон нутгийн орлого*** | ***91350.0*** |
| **1. Хүн амын орлого** | **80400.0** |
| а. Цалин хөлс түүнтэй адилтгах /суутган 1/ | 75000.0 |
| б. Иргэний орого тодорхойлох хуудсаар | 5000.0 |
| в. Патент | 400.0 |
| **2. АТӨЯХ-ийн татвар** | **4000.0** |
| **3. Үл хөдлөх хөрөнгө** | **160.0** |
| **4. Бууны татвар** | **470.0** |
| **5. Нохойны албан татвар** | **500.0** |
| **6. Бусад төлбөр хураамж** | **1520.0** |
| а. Улсын тэмдэгтийн хураамж | 520.0 |
| б. Газрын төлбөр | 700.0 |
| в. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигт малтмал ашигласаны төлбөр | 300.0 |
| **7. Хүү торгууль** | **3550.0** |
| **2. Төсөвт байгууллагын өөрийн орлого** | **750.0** |
| **Хоёр. Тусламжийн орлого** | |
| 2.1. Санхүүгийн дэмжлэг | 197373.4 |
| 2.2. Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг | 300906.0 |
| 2.3. Тусгай зориулалтын шилжүүлэг | 952584.0 |

Хоёр. Сумын 2013 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харъяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

/Мянган төгрөг/

| | | |
|---|---|---|
| **2.1** | **9 жилийн дунд сургууль** | **200.0** |
| **2.2** | **Соёлын төв** | **1000.0** |

Гурав. Сумын 2013 оны орон нутгийн төсвийн зарлагын нийт дүн, төсвийн ерөнхийлөн зархирагчдын төсвийн жилд зарцуулах зарлагын дээд хэмжээг дор дурьдсанаарбаталсугай.

/Мянган төгрөг/

| | | |
|---|---|---|
| **3.1** | **Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга** | **46046.8** |

| | | |
|---|---|---|
| **3.2** | **ЗДТГ** | **187917.0** |
| **3.3** | **Баг** | **50759.0** |

Дөрөв. Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих төсөвт байгууллагын зардлын хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

/Мянган төгрөг/

| | | |
|---|---|---|
| **4.1** | **9-н жилийн дунд сургууль** | **481345.9** |
| **4.2** | **Эрүүл мэндийн төв** | **250230.2** |
| **4.3** | **Цэнгэл цэцэрлэг** | **184249.5** |
| **4.4** | **Соёлын төв** | **36758.4** |

Тав. Сумын ИТХ-ын төсвийн хуваарийг 1 дүгээр хавсралтаар, ЗДТГ-ын төсвийн хуваарийг 2 дугаар хавсралтаар, Багийн төсвийн хуваарийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Зургаа. Сумын хөрөнгө оруулалт, их засварын нэр төрөл, төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг 4 дүгээр хавсралт ёсоор баталсугай.

Долоо. Батлагдсан төсвөө үр ашигтай зарцуулж ажиллахыг төсөв захирагч нарт, төсвийн зарцуулалтыг хагас бүтэн жилээр дүгнэн сумын ИТХ-ын хуралдаанд тайлагнахыг төсвийн ерөнхийлөн захирагч /Сумын Засаг дарга/-д үүрэг болгосугай.

ДАРГА Б.ПҮРЭВСЭНГЭ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 10 өдөр Дугаар _4/1_ Хөвийн ам

Засаг даргын мөрийн хөтөлбөрийн тухай

Сумын Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн тухай сумын Засаг дарга Д.Банзрагчийн илтгэлийг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1.1-ын "г" дэхь заалтыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын ээлжит 4 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. 1. Сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн талаар төлөөлөгчид, урилгаар оролцогчдын гаргасан саналыг багцлан бүлэглэж нэмэн тусгаж хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрөө хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил, улирлаар нарийвчлан боловсруулан мөрдөж хэрэгжилтийг жил бүрийн ИТХ-ын хуралдаанд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга Д.Банзрагчид үүрэг болгосугай.

Хоёр. Хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг улирал тутам дүгнэн мэдээлж, зөвлөмж, чиглэл өгч ажиллахыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ДАРГА Б.ПҮРЭВСЭНГЭ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2013 оны 03 сарын 10 өдөр Дугаар _4/2_ Хөвийн ам

Үндсэн чиглэлийн тухай

Сумын Эдийн Засаг, нийгмийг хөгжүүлэх 2013-2014 оны үндсэн чиглэлийн тухай сумын Засаг даргын илтгэлийг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “а” дахь заалтыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын ээлжит 4 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. 1. Сумын эдийн засаг нийгмийг 2013 оны хөгжүүлэх үндсэн чиглэлд төлөөлөгчид, урилгаар оролцсон хүмүүсийн өгсөн санал, дүгнэлтийг тусган 2013 оны үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Үндсэн чиглэлийн заалтуудыг иргэд, байгууллага, баг бүрт өргөн сурталчилж хэрэгжилтийг зохион байгуулж, улирал тутам дүгнэн, хагас бүтэн жилээр сумын ИТХ-ын хуралдаанд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга Д.Банзрагчид үүрэг болгосугай.

Хоёр. Тогтоол, үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт тавин чиглэл, зөвлөмж өгч хамтран ажиллахыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ДАРГА Б.ПҮРЭВСЭНГЭ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 10 өдөр Дугаар _4/3_ Хөвийн ам

Орон нутгийн хөгжлийн сангийн
төсөвт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, аймгийн ИТХ-ын 2012 оны 2/4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын ээлжит 4 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээг дараах байдлаар баталсугай.

| Д/Д | Хөрөнгө оруулалтын нэр | Мөнгөн дүн /мянган төгрөгөөр/ |
|---|---|---|
| 1 | Наадмын зардал | 5000.0 |
| 2 | Малжуулах /15 өрх 70 мал/ | 73500.0 |
| 3 | Засаг даргын Тамгын газрын зураг төсвийн үнэ /эргэн төлөгдөх/ | 8000.0 |
| 4 | Иргэний танхим байгуулах | 14000.0 |
| 5 | Багийн төв /Давааны ам/ | 35000.0 |
| 6 | Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө | 35000.0 |
| 7 | Шугам сүлжээний өргөтгөл | 11400.0 |
| 8 | Гудамжны гэрэлтүүлэг | 18900.0 |
| 9 | Гудам хороолол камержуулах | 16000.0 |
| 10 | Малын үүлдэр угсаа сайжруулах зардал /эргэн төлөгдөх/ | 4426.0 |
| 11 | Тэжээлийн агуулах засвар | 5000.0 |
| 12 | Хүндэтгэлийн гэр /8 ханатай/ | 13000.0 |
| 13 | Хурдан морьны гарааны төхөөрөмж | 3000.0 |
| 14 | Булгын эх хамгаалах / Нарийний рашаан өргөтгөх, Хужирт толгой/ | 10000.0 |
| 15 | Хог, Усны автомашины урсгал засвар | 3000.0 |
| 16 | Соёлын төвийн зураг төсөв /эргэн төлөгдөх/ | 4500.0 |
| 17 | Халуун усны зураг төсвийн үнэ | 10000.0 |

| | | |
|---|---|---|
| 18 | Хөргүүртэй зоорийн ажлыг эхлүүлэх | 15000.0 |
| 19 | Хүүхэд залуучуудын  тоглоомын талбай тохижуулах ажлыг эхлүүлэх | 3000.0 |
| 20 | Морин мөрт худагийн мотор | 2000.0 |
| 21 | Тэжээлийн агуулах /2 багт шинээр барих/ | 8000.0 |
| 22 | ИТХ-ын тавилга тоног төхөөрөмж | 3180.0 |
| | **Дүн** | **300906.0** |

Хоёр. Батлагдсан төсвөө үр ашигтай зарцуулж ажиллан хагас бүтэн жилээр дүгнэн хэрэгжилт явцыг сумын ИТХ-ын хуралдаанд тайлагнаж ажиллахыг Сумын Засаг дарга /Д.Банзрагч/, төрийн сангийн төлөөлөгч /Б.Цэдэндамбаа/ нарт  үүрэг болгосугай.

Гурав. Төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг сумын ИТХ-ын дарга Б.Пүрэвсэнгэд үүрэг болгосугай.

ДАРГА Б.ПҮРЭВСЭНГЭ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 10 өдөр Дугаар _4/4_ Хөвийн ам

Төлөвлөгөө батлах тухай

Сумын газар зохион байгуулалтын 2013 оны төлөвлөгөөний тухай газрын даамалын илтгэлийг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “з” дэхь заалтыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын ээлжит 4 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Сумын 2013 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд төлөөлөгчид, урилгаар оролцогчдын гагасан саналыг нэмж тусган хавсралтаар баталсугай.

Хоёр. Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжилтийг жилийн эцсийн ИТХ-ын хуралдаанд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга, Газрын даамал нарт үүрэг болгосугай.

ДАРГА Б. ПҮРЭВСЭНГЭ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 10 өдөр Дугаар _4/5_ Хөвийн ам

Ñóì õº ãæ¿¿ëýõ ñàí ãèéí õºðºí ãèéã
á¿ðä¿¿ëýõ, çàðöóóëàõ, õÿí àëò òàâèõ æóðì ûí òóõàé

Сумын жижиг дунд үйлдвэрлэлийн сангийн зарцуулалтын талаар МЭҮТ-ийн жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн Х.Мядагбадамын тайланг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Ì î í ãî ë Óëñûí Çàñãèéí Ãàçðûí 2011 î í û 134 ä¿ãýýð òî ãòî î ëûã тус тус ¿í äýñëýí ñóì ûí ÈÒÕ-ûí ýýëæèò 4 äүгээð õóðàëäààí ààñ ÒÎ ÃÒÎ Î Õí ü:

Í ýã. Ñóì õº ãæ¿¿ëýõ ñàí ãèéí 2013 î í û çýýëèéí õ¿¿ãèéí õýì æýýã 3 /гурав/ õóâèàð òî ãòî î ñóãàé.

Õî ¸ ð. Ñóì õº ãæ¿¿ëýõ ñàí ãààñ 2013 î í ä í ýã çýýëä î ëãî õ äýýä õýì æýýã 25000000 /Хорин таван сая/ òº ãðº ãáî ëãî ñóãàé.

Ãóðàâ. 1. Òº ñº ë ñî í ãî í øàëãàðóóëàõ ÷èã ¿¿ðýã á¿õèé î ðî í òî î í û áóñ çº âëº ëèéã 1 ä¿ãýýð õàâñðàëòààð

2. Ñàí ãèéí õº ðº í ãèéí çàðöóóëàëò, çýýëèéí àø èãëàëò, ýðãýí òº ëº ëò, òàéëàãí àëòàä õÿí àëò òàâèõ ÷èã ¿¿ðýã á¿õèé î ðî í òî î í û áóñ çº âëº ëèéã 2 äóãààð õàâñðàëòààð òóñ òóñ ñî í ãî í áàòàëñóãàé.

Äº ðº â. Ñàí ãèéí ¿éë àæèëëàãààí û ¿ð ä¿í ã æèë á¿ð ñóì ûí ÈÒÕ-ûí õóðàëäààí ä òàéëàãí àæàæèëëàõû ã ñóì ûí Çàñàã äàðãà Д.Банзрагчид ¿¿ðýã áî ëãî ñóãàé.

Òàâ. Ñàí ãèéí ¿éë àæèëëàãààí ä õèéñýí õÿí àëò, øàëãàëòûí ä¿í ã æèë á¿ðèéí ÈÒÕ-ûí õóðàëäààí ä òàí èëöóóëæ àæèëëàõû ã õÿí àëòûí çº âëº ëä үүрэг болгоñóãàé.

Зургаа. Олгогдсон зээлийн хүүгийн орлогоос 800000 мянган төгрөгийг Төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл, õөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад õÿí àëò тавих чиг үүрэг бүхий орон тооны бус çөâëөëийн үйл ажиллагаанд зарцуулахыг зөвшөөрсүгэй.

Долоо. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан сумын ИТХ-ын 2011 оны 10/3 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ÄÀÐÃÀ Á.Ï ¯ÐÝÂÑÝÍ ÃÝ

Ñóì ûí ÈÒÕ-ûí ýýëæèò 4 дүгээð
õóðàëäààí û 4/5 äóãààð
òî ãòîîëûí 1 ä¿ãýýð õàâñðàëò

ÑÓÌ Õª ÃÆ¯¯ËÝÕ ÑÀÍ ÃÈÉÍ Òª Ñª Ë ÑÎ Í ÃÎ Í
ØÀËÃÀÐÓÓËÀÕ ×ÈÃ¯¯ÐÝÃ Á¯ÕÈÉ Î ÐÎ Í ÒÎ Î Í Û ÁÓÑ Çª ÂËª Ë

Äàðãà: Ñóì ûí Çàñàã äàðãà /Д.Банзрагч/

Í àðèéí áè÷ãèéí äàðãà: МЭҮТ-ийн Жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн /Х.Мядагбадам/

Ãèø ¿¿ä: ЗДТГ-ын дарга /П.Тогтохжаргал/

Òºðèéí ñàí ãèéí òºëººëºã÷ /Б.Цэдэндамбаа/

Èðãýí èé òºëººëºë: Төлөөлөгч Д.Далай

Төлөөлөгч Б.Нансалмаа

Төлөөлөгч Д.Болд-Аюуш

_________oOo________

Ñóì ûí ÈÒÕ-ûí ýýëæèò 4 äүгээð
õóðàëäààí û 4/5 äóãààð
òî ãòîîëûí 2 äóãààð õàâñðàëò

ÑÓÌ Õª ÃÆ¯¯ËÝÕ ÑÀÍ ÃÈÉÍ Õª Ðª Í ÃÈÉÍ ÇÀÐÖÓÓËÀËÒ,
ÇÝÝËÈÉÍ ÀØÈÃËÀËÒ, ÝÐÃÝÍ Òª Ëª ËÒ, ÒÀÉËÀÃÍ ÀËÒÀÄ
ÕßÍ ÀËÒ ÒÀÂÈÕ ×ÈÃ¯¯ÐÝÃ Á¯ÕÈÉ
Î ÐÎ Í ÒÎ Î Í Û ÁÓÑ Çª ÂËª Ë

Àõëàã÷ : Ñóì ûí ÈÒÕ-ûí Тºëººëºã÷ Д.Баяржаргал

Нарийн бичиг: ÈÒÕ-ûí Төлөөлөгч Р.Цогт

Ãèø ¿¿ä: ÈÒÕ-ûí Òýðã¿¿ëýã÷ Ц.Баатаржав

ÈÒÕ-ûí Òýðã¿¿ëýã÷ Э.Жавхлан

ÈÒÕ-ûí Төлөөлөгч Ц.Энхболд

ÈÒÕ-ûí Òºëººëºã÷ Д.Энхээ

ÈÒÕ-ûí Òºëººëºã÷ Ч.Эрдэнэ-Очир

___________oOo_________

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 10 сарын 01 өдөр Дугаар _5/1_ Хөвийн ам

Хуралдааны дэг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.14 дэх заалтыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын ээлжит 5 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдаанаас бусад хуралдааны дэгийн төсөлд төлөөлөгчдийн гаргасан саналыг нэмж тусган хавсралтаар батлсугай.

Хоёр. Батлагдсан дэгээ мөрдөн ажиллахыг төлөөлөгчдөд, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг хуралдааны даргад үүрэг болгосугай.

ДАРГА Б. ПҮРЭВСЭНГЭ

Сумын ИТХ-ын ээлжит 5 дугаар хуралдааны
5/1 -р тогтоолын хавсралт

***ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ДЭГ***

**1 дүгээр зүйл. Дэгийн зорилт**

1.1. Энэхүү дэгийн зорилт нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Хурлын хороо, түр хороодын хуралдаан /цаашид "хуралдааны" гэх /-ыг зохион байгуулах, хуралдаанаар тодорхой асуудал хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргах дэг журамтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Нийтлэг үндэслэл**

2.1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан мөн.

2.2 Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралданы зохион байгуулалт, үйл ажиллагааг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль болон энэ дэгээр зохицуулна.

2.3 Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь дарга, Тэргүүлэгчдийн ажлын албатай байх бөгөөд ажлын албаны бүтцийг хурлын Тэргүүлэгчид тогтооно.

**3 дугаар зүйл. Хуралдааны үндсэн зарчим**

3.1 Хуралдаан хууль дээдлэх, асуудлыг чөлөөтэй хэлэлцэж, цөөнхийн саналыг хүндэтгэн сонсож олонхийн саналаар шийдвэрлэх зарчмыг удирдлага болгоно.

3.2 Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч /цаашид "Хурлын төлөөлөгч гэх" / хуралдааныг товлон зарласан цагт хүрэлцэн ирэх үүрэгтэй.

**4 дүгээр зүйл. Хуралдааны тов, ирц ба хэлэлцэх асуудал**

4.1 Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын / цаашид "Хурал" гэх / ээлжит хуралдааныг улиралд 1-ээс доошгүй удаа, ээлжит бус хуралдааныг төлөөлөгчдийн гуравны хоёроос доошгүйн шаарсанаар, эсхүл Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр өөрийн онцгой бүрэн эрх болон хууль тогтоомжид заасан бусад эрхэд хамаарах асуудлын хүрээнд тогтмол хуралдуулна.

4.2 Цаг үеийн шаардлагатай асуудлаар Хурлын Тэргүүлэгчид энэ дэгийн 4.1-д заасан ээлжит хуралдааны чөлөө цагт хуульд заасан өөрийн бүрэн эрхийн асуудлаар хуралдаж тогтоол гаргах бөгөөд энэ талаар Хуралд тайлагнаж ажиллана.

4.3 Хурлын хуралдааны бэлтгэл хангах, хэлэлцэх асуудал боловсруулах зорилгоор нам, эвслийн бүлэг, Хурлын хороо, түр хороодын хуралдааныг хуралдуулж болно.

4.4 Хурлын ээлжит ба ээлжит бус хуралдааны хэлэлцэх асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар тогтоож таваас доошгүй хоногийн өмнө зарлах бөгөөд Хурлын төлөөлөгч болон сумын Засаг дарга нь Хурлын хэлэлцэх асуудлын дараалалд энэ дэгт заасан хуралдааны бэлтгэл ажил ба хэлэлцүүлгийн шаардлага хангасан асуудлыг оруулж хэлэлцүүлж болно.

4.5 Шаардлагатай тохиолдолд нам эвслийн бүлэг хуралдаанаас тухайн хэлэлцэж буй асуудлаар завсарлага авч болох бөгөөд завсарлагын хугацаа дээд тал нь ажлын тав хоног байна. Завсарлага авч буй нам эвслийн бүлэг албан бичгээр мэдэгдэх ба алан бичигт завсарлагын эхлэх, дуусах хугацааг тодорхой тусгана.

4.6 Хуралдаанд бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөн нийт төлөөлөгчийн олонхи оролцсоноор ирцийг хүчин төгөлдөрт тооцно. /50 буюу түүнээс дээш хувь/

4.7 Хурлын төлөөлөгч нэгдсэн хуралдаанд хүндэтгэх шалтгаанаар ирэх боломжгүйд хүрвэл Хурлын дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргад мэдэгдэж, хэлэлцэх асуудалтай холбоотой саналаа урьдчилан бичгээр ирүүлж болох бөгөөд зөвхөн ирүүлсэн саналтай холбоотой асуудлыг шийдвэрлэх санал хураалтын хувьд

дэмжсэнд тооцно. Харин хурлын ирцийг тооцоход тухайн төлөөлөгчийг оруулж тооцохгүй.

4.8 Хурлын Төлөөлөгч өвчтэй байсан буюу өвчтэй хүн асарсан, гадаад, дотоод томилолтоор явсан, түүнчлэн хурал, уулзалтанд зайлашгүй оролцох шалтгаантай байсан бол хүндэтгэх шалтгаантай гэж үзэх бөгөөд эдгээр шалтгаан байхгүй бол хуралдаан тасалсанд тооцно.

4.9 Хурлын төлөөлөгч, нам эвслийн бүлэг шалтгаангүйгээр хуралдаанд оролцохгүй байх буюу түүнийг орхиж гархыг хориглоно.

4.10 Хурлын Төлөөлөгч, нам эвслийн бүлэг шалтгаангүйгээр хуралдаанд оролцоогүй буюу орхиж гарсан бол хуралдаанд оролцож эсрэг санал өгсөнд тооцож санал хураалт явуулна.

4.11 Хуралдаанаар Хурал өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлын зэрэгцээ эрх бүхий дээд шатны байгуулагаас сумын ИТХ-аар шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн асуудал, сумын Засаг дарга болон хурлын Тэргүүлэгчдээс өөрсдийн эрх хэмжээний асуудлыг шийдвэрлүүлэхээр оруулсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэж болно.

4.12 Хуралдааны дэгд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлыг Хурлын Төлөөлөгчдийн тавны нэгээс доошгүйн саналаар ээлжит хуралдаанаар хэлэлцүүлнэ. Нэмэлт өөрчлөлтийг нийт Төлөөлөгчдийн ердийн олонхийн саналаар батална.

4.13 Төлөөлөгч хуралдаанд хуралдааныг товлосон цагт ирсэн байх ба хуралдааныг цагт нь эхлүүлнэ. Энэ асуудлыг журмаар зохицуулна.

**5 дугаар зүйл. Хурлын хуралдаанд асуудал оруулах эрх**

5.1 Хурлын төлөөлөгч, Хурлын хороо, Нам, эвслийн бүлэг, сумын Засаг дарга асуудал санаачлан Хуралд хэлэлцүүлэхээр оруулах эрхтэй.

5.2 Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж иргэн Хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно.

5.3 Хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг Хурлын даргад өргөн барьж, Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулах эсэхийг шийдвэрлэнэ. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулах боломжгүй бол энэ тухайгаа хариу мэдэгдэнэ.

5.4 Хуралдаанаар хэлэлцүүлэх асуудал тодорхой төсөв, зохион байгуулалт, хүн хүч шаардсан ажил бол сумын Засаг даргын саналыг заавал авсан байх ёстой. Хурлын төлөөлөгчөөс санал авахаар ирүүлсэн асуудлын төслийг сумын Засаг дарга судалж үзээд ердийн боломжит хугацаанд санал өгөх ба хамгийн ойрийн ээлжит хуралдаанд амжиж санал өгөөгүй бол дараагийн ээлжит хурлаас өмнө заавал санал өгсөн байна.

**6 дугаар зүйл. Хуралдааны шийдвэр**

6.1. Хурал хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргах бөгөөд тогтоолын тухайн хурлын хуралдаанд оролцсон төлөөөлөгчдийн олонхийн саналаар батална.

6.2 Хурлын тогтоолд Хурлын дарга, Хурлын даргыг сонгох, чөлөөлөх тухай тогтоолд тухайн хуралдаан даргалагч тус тус гарын үсэг зурна.

6.3 Хурлын шийдвэрийг иргэдэд сурталчилах ажлыг сумын Засаг дарга, ИТХ-ын ажлын алба, Засаг даргын Тамгын газар, албан байгууллагын дарга эрхлэгч нар хариуцан мэдээлнэ.

6.4 Хурлын шийдвэр нь хууль тогтоомжид нийцээгүй бол түүнийг хурал өөрчлөх буюу хүчингүй болгоно.

**7 дугаар зүйл. Хурлын шийдвэрт хориг тавих**

7.1 Хурал үндсэн хууль, бусад хууль тогтоомж зөрчсөн эсхүл өөрийнх нь бүрэн эрхэд үл хамаарах, түүнчлэн хэрэгжих санхүүгийн болон бусад эх үүсвэргүй шийдвэр гаргасан бол Засаг дарга холбогдох шийдвэрт бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эрхтэй.

7.2 Засаг дарга Хурлын шийдвэрт хориг тавьсантай холбоотой харилцааг Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 27-р зүйлд заасан журмаар шийдвэрлэнэ.

**8 дугаар зүйл. Хуралдааны бэлтгэл ажиллагааг хангах журам**

8.1 Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, бусад хуулинд хэлэлцэхээр заасан асуудлууд, хурлын байгууллагаас сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх ажлын үндсэн чиглэл, Хурлын Тэргүүлэгчдийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан асуудлуудыг ээлжит хуралдааны хугацаанд нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

8.2 Нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан илтгэл, гарах шийдвэрийн төслийн асуудал оруулж байгаа Төлөөлөгч болон Хурлын ажлын алба, Засаг дарга түүний Тамгын газар боловсруулна.

8.3 Нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудалыг шаардлагатай тохиолдолд тухайн асуудал эрхэлсэн хорооны хурлаар урьдчилан хэлэлцэж, нэгдсэн санал дүгнэлтийг хуралдаанд оруулна. Хурлын хуралдаанаар хэлэлцэх илтгэл, сонсгол, мэдээллийг Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан болон Засаг даргын зөвлөлийн хурлаар урьдчилан хэлэлцэж, илтгэл, илтгэгчийг батална.

8.4 Нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлын талаар бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргах, хорооны санал дүгнэлт бэлтгэх, сурталчлах ажлыг тухайн хорооны дарга, нам, эвслийн бүлэг, Хурлын ажлын алба, сумын Засаг даргын Тамгын газрын ажлын алба тус тусын үүргийн дагуу хариуцна.

8.5 Нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудалд холбогдох тооцоо, судалгаа, лавлагаа, гаргах шийдвэрийн төслийг хавсаргаж хуралдаан болохоос 1-ээс доошгүй хоногийн өмнө Хурлын төлөөлөгчдөд тараах бөгөөд энэхүү шаардлагыг хангаагүй асуудлыг хуралдаанаар хэлэлцэхгүй. Энэхүү заалт нь анхдугаар хуралдаанд хамаарахгүй.

8.6 Хуралдаанд хэлэлцэх асуудалтай холбогдуулан хуралдаанд урилгаар оролцох албан тушаалтны нэрсийг Хурлын дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргатай зөвшилцөн урилгыг Хурлын ажлын албанаас 2-оос доошгүй хоногийн өмнө хүргүүлнэ.

8.7 Нэгдсэн хуралдааныг хэвийн явуулах бэлтгэлийг хангах, хүндэтгэлийн туг, сүлд болон шаардлагатай тэхник тоног төхөөрөмж /хуралдааны байр бэлдэх/-ийг Засаг Даргын Тамгын Газар урьдчилан хангасан байна.

**9 дүгээр зүйл. Хурлын хуралдааныг зохион байгуулах журам**

9.1 Хурлын хуралдааныг нээлттэй, хаалттай хэлбэрээр зохион байгуулж болно.

9.2 Нээлттэй хуралдааны үед дараахь журмаар хуралдааны ажиллагааг зохион байгуулна.

Үүнд:

9.2.1 Хурлын төлөөлөгчид, урилгаар оролцогсод, хэвлэл мэдээллийн ажилтнууд, иргэдийн төлөөлөл хуралдаан эхлэхээс өмнө суудлаа эзэлсэн байна. Хуралдааны ирц, урилгаар суугчдын талаар Хурлын ажлын албанаас хурал даргалагчид урьдчилан мэдэгдэх.

9.2.2 Хуралдаан эхлэхээс өмнө танхимд Монгол улсын төрийн сүлд дууллыг эгшиглүүлнэ.

9.2.3 Хуралдаан даргалагч хуралдааныг нээж товч үг хэлэх бөгөөд төлөөлөгчдийн ирц, урилгаар оролцож байгаа хүмүүсийн талаар танилцуулна.

9.2.4 Хуралдаан дагалдагч дараалал, хэлэлцэх асуудлыг танилцуулж батлуулах.

9.2.5 Хэлэлцэх асуудалтай холбоотой илтгэл, сонсгол мэдээлэл нь Төлөөлөгчдөд урьдчилан тараасан бол түүнийг бүтнээр нь сонсохгүйгээр тайлбар авч, санал, дүгнэлтийг нэгтгэн сонсож, гаргах шийдвэрийн төслийг хэлэлцэнэ. Хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудалд холбогдох зураг, хүснэгт танилцуулга, дүрс ба дууны бичлэг, видео бичлэг, биет зүйлс түүний загвар хэсгийг хуралдаанд үзүүлж болно.

9.4. Төлөөлөгчид хуралдаанд оролцохдоо хуралдааны дэг, хуралдааны даргын шаардлагыг биелүүлэх үүрэгтэй бөгөөд үг хэлэх, санал шүүмжлэл гаргах, асуулт тавих эрхийг дараахь байдлаар эдэлнэ. Үүнд:

9.4.1 Үг хэлэх, асуулт асуухаа урьдчилан мэдэгдэн дараалалд орж хуралдаан даргалагчаас зөвшөөрөл авах.

9.4.2 Тогтоосон хугацаанд өөрөө үг хэлэх, асуулт асуух энэхүү эрхээ бусад төлөөлөгчдөд шилжүүлэхгүй байх.

9.4.3 Хуралдаан даргалагч зөвшөөрөл өгөөгүй байхад үг хэлэх буюу асуулт тавих энэхүү эрхээ эдлэхдээ бүдүүлэг үг хэллэг хэрэглэх бусдыг доромжлох, нэр төрийг нь гутаах, басамжлах, яриаг нь таслах өмнөөс нь үг хэлэх өөрийн саналыг дэмжүүлэх буюу бусдын саналыг үгүйсгэх зорилгоор үзүүлэх, хүч хэрэглэх зэрэг үйлдэл гаргахгүй байх.

9.4.4 Төлөөлөгч хэлэлцэж байгаа асуудал бүрээр эхний удаад 5 минут, дараагийн удаад 2 минут хүртэл хугацаагаар үг хэлнэ. Үг хэлэх хугацааг тухайн хэлэлцэх асуудлаас шалтгаалан тухайн хуралдаанаас тогтооно.

9.4.5 Төлөөлөгч хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан төр захиргааны албан тушаалтанд хандаж асуулга тавьж хариу авч болно. Тавьсан асуулганд тухайн хурал дээр хариу өгөх боломжгүй бол хариуг албан бичгээр мэдэгдэнэ.

9.5 Хэлэлцэж байгаа асуудлаар Төлөөлөгчдийн гаргасан горимын саналыг сонсох, түүгээр санал хураалгаж болно. Горимын санал гэж хуралдаанаар тухайн асуудлыг хэрхэн хэлэлцэж шийдвэрлэх талаар Төлөөлөгчдөөс гаргасан саналыг ойлгоно.

9.6 Хуралдааны санал шүүмжлэлийг төлөөлөгчдийн олонхийн саналаар тасална. Шаардлагатай гэж үзсэн цөөнхийн саналыг тусгайлан хэлэлцэж хуралдааны шийдвэрт болон тэмдэглэлд тусгана. Төлөөлөгч нь санал шүүмжлэлээ бичгээр гаргаж болно.

9.7 . Тодорхой асуудал хэлэлцэх явцад шаардлагатай бол Хуралдааны даргын болон төлөөлөгчдийн олонхийн саналаар хуралдааныг түр завсарлуулж болох бөгөөд завсарлагааны хугацааг Хуралдааны дарга тогтооно.

9.8 Хурлын тогтоол бусад баримт бичгийн төслийг нарийвчлан хянаж төлөөлөгчдийн санал шүүмжлэлийг тусгаж нягтлан боловсруулах зорилгоор хуралдаанаас гарах шийдвэрийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулж болно.

9.9 Төлөөлөгч нь хуралдаанд хэлэлцүүлэхээр тогтоолын төсөл оруулах, тогтоолын төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, засвар хийх эрхтэй. Тогтоолын төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналыг төлөөлөгчдөөр хэлэлцүүлж, тэдний олонхийн саналаар шийдвэрлэнэ.

9.10 Хуралдааны дарга нь бичгээр санал, асуулт, асуулгын талаар төлөөлөгчдөд сонгох, танилцуулж хэлэлцүүлэх, хэлэлцсэн асуудлаар төлөөлөгчдийн саналыг хураах дүнг мэдээлж, эцсийн шийдвэрийг батлуулна.

9.11. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тавьсан санал хүсэлт, өргөдөл гомдолыг хүлээн авч хэрхэн хэлэлцэх журмыг хурал өөрөө тогтоож мөрдөнө.

**10 дугаар зүйл. Нээлттэй хуралдааны дэг**

10.1 Нээлттэй хуралдаанд хэлэлцэж байгаа асуудлыг боловсруулахад оролцсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн, түүнчлэн хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчид, иргэдийн төлөөлөл ажиглагчаар оролцож болно.

10.2 Нээлттэй хуралдааны явцыг дуу, дүрс бичлэг, мэдээллийн бусад хэрэгсэлийг ашиглан бэхжүүлнэ.

10.3 Нээлттэй хуралдаанд ажиглагчаар оролцох иргэдийн хүсэлтийг урьдчилан авах бөгөөд эхэлж хүсэлт тавьсан иргэдийн төлөөллийг оролцуулна.

**11 дугаар зүйл. Хуралдаан даргалагчийн эрх, үүрэг**

11.1. Хуралдааныг Хурлын дарга, түүний эзгүйд Хурлын даргын санал болгосноор Тэргүүлэгчдийн аль нэг нь нээж удирдана. Хуралдааныг зохион байгуулах талаар хуралдаан даргалагч дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

11.1.1. Хуралдааны товыг тогтоон зарлаж бэлтгэлийг хангах

11.1.2. Хуралдааныг товлосон цагт эхлүүлж дэгийн дагуу зохион байгуулж, зөрчигдвөл таслан зогсоох

11.1.3. Саналаа ирүүлсэн дарааллыг баримтлан төлөөлөгчдөд асуулт асуух, үг хэлэх зөвшөөрөл өгөх

11.1.4. Төлөөлөгчдөөс гаргасан горимын саналаар санал хураалт явуулах

11.1.5. Санал хураалт явуулж, дүнг мэдээлэх

11.1.6. Хуралдааны шийдвэрийг хэлбэржүүлэх ажлыг зохион байгуулах

11.1.7. Ирц хүрэлцэхүйц байвал хүндэтгэх шалтгаантай төлөөлөгчид чөлөө өгөх
11.1.8. Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх, үүрэг
11.2. Асуудлыг хэлэлцэж журам, дарааллын талаар төлөөлөгчөөс гаргасан саналыг горимын гэх бөгөөд түүгээр нэг удаа санал хураана.
11.3. Хурлын хуралдаан, Тэргүүлэгчдийн хурал болон хороо, түр хороодын хуралдааны хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчилах ажлыг зохион байгуулна.

**12 дугаар зүйл. Хуралдааны тэмдэглэл хөтлөх журам**
12.1 Хуралдаан бүр дээр түүний үйл ажиллагааг нарийн тэмдэглэсэн тэмдэглэлийг хөтлөнө. Үүнд:
12.1.1. Хуралдааны дугаар, хуралдаан хийсэн он, сар, өдөр,
12.1.2. Хуралдааны ажиллагаа эхэлсэн, дууссан , илтгэл, хавсралт илтгэл, санал, шүүмжлэл, асуулт, хариулт, асуулга, тайлбар, лавлагаа өгсөн хугацааны хамт тэмдэглэнэ.
12.1.3. Хуралдааны ирц тоо, хувиар байхгүй байсан төлөөлөгчийн нэр, шалтгаан,
12.1.4. Хуралдаан нээсэн хүний овог нэр, хуралдааны дарга, нарийн бичгийн даргад хэний саналаар, ямар албан тушаалтай, хэн хэнийг сонгосон
12.1.5. Илтгэл хавсралт илтгэл, бусад асуудлыг ямар албан тушаалтай хэн оруулсан
12.1.6. Илтгэгчдээс асуусан асуулт, түүнд өгсөн хариулт
12.1.7. Санал, шүүмжлэл гаргасан төлөөлөгч, урилгаар оролцсон хүмүүсийн нэр, албан тушаалтан
12.1.8. Хуралдааны ажиллагааны явцад тавигдсан асуулга, түүнд хуралдаан дээр өгсөн бол гол утга
12.1.9. Баталсан шийдвэрүүдийн нэр, хурлын тогтоолуудыг хэлэлцүүлж батлуулсан журам, саналын дүн
12.1.10. Хуралдааны явцад хэлэлцсэн, сонордуулсан, тараасан баримт бичиг,
12.1.11. Төлөөлөгчид тусгайлан тэмдэглүүлэхээр өөрөө бичсэн
12.1.12. Хуралдаанд хоцорч ирсэн, чөлөө авсан, өвчтэй байсан, тасалсан, хуралдааны даргын зөвшөөрөлгүйгээр гарч явсан төлөөлөгчийн нэр, цаг минут,
12.1.13. Төлөөлөгчдийн хуралдаанд хэлсэн үгийг тодорхой бичих бөгөөд тусгайлан тэмдэглүүлсэн зүйлийг тухайн төлөөлөгчдөд хянуулж гарын үсэг зуруулна.
12.1.14. Хуралдааны тэмдэглэлд дарга, хуралдааны нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, хуралдааны материалд хавсаргана.
12.2. Хуралдааны тэмдэглэл нийтэд нээлттэй байх бөгөөд хүссэн иргэн нь танилцаж болох ба хэсэгчлэн хувилж авч болно.

**13 дугаар зүйл. Хурлын шийдвэрийг зохион байгуулах**
13.1. Хуралдааны тогтоолыг мөрдөх хугацааг жичид нь заагаагүй бол уг хуралдаан болсон өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
13.2. Хуралдааны шийдвэрийг мэдээлж сурталчлах, биелэлтийг зохион байгуулах ажлыг Тэргүүлэгчдид, Хурлын төлөөлөгч, Хурлын ажлын алба, Засаг дарга түүний Тамгын газар, мэргэжилтнүүд, албан байгууллагын дарга, эрхлэгч нар хариуцна.
13.3. Хуралдаан дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор хуралдааныг бэлтгэж хийлгэсэн ажлын үр дүнг хэлэлцэх, хурлын тогтоолын биелэлтийг зохион байгуулна.
13.5. Хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлж байгаа ажлын явц, үр дүнгийн талаар сумын Засаг дарга, түүний Тамгын газар, мэргэжилтнүүд, албан байгууллага, аж ахуйн нэгж дээр шалгах, тэдгээрийн удирдлагуудын илтгэл, сонсголыг хэлэлцэх ажлыг хийж дүгнэлт өгч болно.
13.6. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу хурлын шийдвэр биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцож байна.
13.7. Хурлын шийдвэрийн биелэлтийн талаар Хурал, түүний Тэргүүлэгчид тусгайлан хэлэлцэж чиглэл өгөх, хугацаатай даалгавар өгөх, шаардлага тавих, хариуцлага тооцох зэргээр ажиллаж гаргасан шийдвэрээ ажил хэрэгч болгохын төлөө ажиллана.

**14 дугаар зүйл. Онцгой үеийн шийдвэр гаргах ажиллагаа**

14.1. Байгалын гамшиг, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, гал түймэр зэрэг нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд заналхийлсэн аливаа үзэгдэл, үйлдлийн эсрэг авсан шуурхай арга хэмжээтэй холбоотойгоор аймгийн Засаг дарга захирамж гаргасан бол сумын Засаг дарга Хурлын даргад нэн даруй мэдэгдэж хүргүүлнэ.

14.2. Энэ зүйлийн 13.1 дэх хэсэгт заасан мэдэгдлийг хүлээн авсан дариуд Хурлын Тэргүүлэгчдийн хурлыг Хурлын дарга зарлах ба Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар аймаг, сумын Засаг даргын гаргасан захирамжийг авч хэлэлцэж тодорхой шийдвэр гаргана.

14.3. Онцгой дэглэм тогтоосон, гэнэтийн аюулын үр дагаварыг арилгахтай холбогдуулан түр журам гаргасан, нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, даамжрахаас урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан сумын Засаг даргын захирамжыг хэлэлцэхдээ нөхцөл байдлын тухай дэлгэрэнгүй мэдээллийг нутаг дэвсгэрийн цагдаа, онцгой байдал, мэргэжилтэн, хүн ба мал эмнэлэгийн газар зэргээс авсаны үндсэн дээр бодитойгоор үнэлж шийдвэр гаргана.

**15 дүгээр зүйл. Хурлын дэг хүчин төгөлдөр болох**

15.1 Энэхүү Хурлын дэг батлагдсан өдрөөс  эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 09 сарын 05 өдөр　　Дугаар _5/2_　　Хөвийн ам

¯í äñýí ÷èãëýëèéí õýðýãæèëò
ÿâöûí òóõàé

Ñóì ûí ýäèéí çàñàãíèéã èéã õº ãæ¿¿ëýõ 2013 î í û ¿í äñýí ÷èãëýëèéí õýðýãæèëòèéí ÿâöûí òóõàé ñóì ûí Çàñàã äàðãын Тамгын газрын даргын èëòãýëèéã õýëýëöýä ÒÝÌ ÄÝÃËÝÕ í ü:

Ñóì ûí ýäèéí çàñàãíèéã èéã õº ãæ¿¿ëýõ 2013 î í û ¿í äñýí ÷èãëýëèéí í èéò 137 çààëòààñ 100 õóâü õýðýãæñýí 18 çààëò, 70-90 õóâü õýðýãæñýí 34 çààëò, 40-60 õóâüòàé 40 çààëò, 10-30 õóâüòàé 22 çààëò, î ãò õýðýãæýýã¿é çààëò 23 áàéãàà áà õýðýãæèëò 51.39 õóâüòàé áàéãàà í ü æèëèéí ¿ëäñýí õóãàöààòàé õàðüöóóëàõàä õýðýãæèëò хангалтгүй áàéí à. Ì î í ãî ë Óëñûí Çàñàã çàõèðãàà í óòàã äýâñãýðèéí í ýãæ ò¿¿í èé óäèðäëàãûí òóõàé õóóëèéí 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 18.1.2-н "а" дахь заалтыг үндэслэн сумын ÈÒÕ-ûí ýýëæèò 5 äóãààð õóðàëäààí ààñ ÒÎ ÃÒÎ Î Õ í ü:

Í ýã. Èëòãýëä òº ëº º ëº ã÷äèéí º ãñº í çº âëº ì æ ñàí àëû ã òóñãàí　50-ààñ äî î ø õóâüòàé áàéãàà çààëòóóäûã ì º í õýðýãæèæ ýõëýýã¿é áàéãàà çààëòóóäûã õýðýãæ¿¿ëýõ òàëààð òº ëº âëº ãº º ãàðãàí ñàð á¿ð õýðýãæèëòèéг òî î öî í àæèëëàõûã ñóì ûí Çàñàã äàðãà Ä. Áанзрагчид ¿¿ðýãáî ëãî ñóãàé.

Õî ¸ ð. ¯í äñýí ÷èãëýëèéí õýðýãæèëò ÿâöûã сар á¿ð ñóì ûí ÈÒÕ-ûí Òýðã¿¿ëýã÷äèéí õóðëààð ñî í ñî æ õýðýãæèëòèéã õàí ãàõàä ÷èãëýñýí çº âëº ì æ ÷èãëýë º ã÷ àæèëëàõûã ñóì ûí ÈÒÕ-ûí Òýðã¿¿ëýã÷äýä äààëãàñóãàé.

ÄÀÐÃÀ　　　　Á.Ï ¯ÐÝÂÑÝÍ ÃÝ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2013 оны 09 сарын 05 өдөр Дугаар _5/3_ Хөвийн ам

Орон нутгийн хөгжлийн сангийн
төсөвт дахин өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, аймгийн ИТХ-ын 2012 оны 2/4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын ээлжит 4 дүгээр хуралдаанаасТОГТООХ нь:

Нэг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээг дараах байдлаар баталсугай.

| Д/Д | Хөрөнгө оруулалтын нэр | Мөнгөн дүн /мянган төгрөгөөр/ |
|---|---|---|
| 1 | Наадмын зардал | 5000.0 |
| 2 | Малжуулах /15 өрх 70 мал/ | 73500.0 |
| 3 | Засаг даргын Тамгын газрын зураг төсвийн үнэ /эргэн төлөгдөх/ | 7100.0 |
| 4 | Иргэний танхим байгуулах | 14000.0 |
| 5 | Багийн төв /Давааны ам/ | 35000.0 |
| 6 | Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө | 35000.0 |
| 7 | Шугам сүлжээний өргөтгөл | 11400.0 |
| 8 | Гудамжны гэрэлтүүлэг | 18900.0 |
| 9 | Гудам хороолол камержуулах | 16000.0 |
| 10 | Малын үүлдэр угсаа сайжруулах зардал /эргэн төлөгдөх/ | 5926.0 |
| 11 | Тэжээлийн агуулах засвар | 5000.0 |
| 12 | Булгын эх хамгаалах / Нарийний рашаан өргөтгөх, Хужирт толгой/ | 10000.0 |
| 13 | Хог, Усны автомашины урсгал засвар | 2520.0 |
| 14 | Халуун усны зураг төсвийн үнэ | 10000.0 |
| 15 | Морин мөрт худагийн мотор | 2000.0 |
| 16 | Тэжээлийн агуулах /2 багт шинээр барих/ | 9000.0 |

| | | |
|---|---|---|
| 17 | Багийн төв /Хөвийн ам 4-р баг/ | 35000.0 |
| 18 | Гамшигаас хамгаалах тэжээлийн нөөц | 5560.0 |
| | **Дүн** | **300906.0** |

Хоёр. Батлагдсан төсвөө үр ашигтай зарцуулж ажиллан хагас бүтэн жилээр дүгнэн хэрэгжилт явцыг жилийн эцсийн сумын ИТХ-ын хуралдаанд тайлагнаж ажиллахыг Сумын Засаг дарга /Д.Банзрагч/, төрийн сангийн төлөөлөгч /Б.Цэдэндамбаа/ нарт үүрэг болгосугай.

Гурав. Төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг сумын ИТХ-ын дарга Б.Пүрэвсэнгэд үүрэг болгосугай.

Дөрөв. Хөвийн амны 4 дүгээр багийн төвийн барилгын асуудлыг 2013 оны тендерт нэмж оруулах болон хөрөнгө нь шийдэгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг дулааны улиралд багтаан зохион байгуулахыг сумын Засаг дарга Д. Банзрагчид үүрэг болгосугай.

ДАРГА Б. ПҮРЭВСЭНГЭ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 09 сарын 06 өдөр Дугаар _5/4_ Хөвийн ам

Газар зохион байгуулалтын 2013 оны
тº ëº âëº ãº º í ä өөрчлөлт î ðóóëàõ òóõàé

Ì î í ãî ë Óëñûí Çàñàã çàõèðãàà í óòàã äýâñãýðèéí í ýãæ ò¿¿í èé óäèðäëàãûí òóõàé õóóëèéí 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Ãàçðûí òóõàé õóóëèéí 20 äóãààð ç¿éëèéí 1.2 äàõü çààëò, сумын 2013 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг тус тус ¿í äýñëýí ñóì ûí ÈÒÕ-ûí ýýëæèò 5 äóãààð õóðàëäààí ààñ ÒÎ ÃÒÎ Î Õ í ü:

Í ýã. Сумын 2013 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд дараах газруудыг нэмж олгохоор батлсугай. Үүнд:

- Хүүхэд залуучуудын паркийн газрыг Хуучин эмнэлэгийн барилгын ард 0.6 га талбай
- Дэд станцын барилгыг Хуучин усан сангийн хуучин суурьнаас доош 300 метерт Эрчим хүчний өргөтгөл хийх зориулалтаар 28 м$^2$ талбай
- Өсөн дэвжих арвижих хоршоонд Хөвийн амны 4 дүгээр баг Богочны үзүүрт хүнсний ногоо тариалах зориулалтаар 2 га талбай
- Хөвийн амны 4-р багийн төвийн барилгын газрыг багийн ИНХ-ын гаргасан шийдвэрээр 70м$^2$ талбай
- Хөвийн амны 4-р багийн гүн өрмийн худгийг Богочны үзүүр Хар усан голын захад 50 м$^2$ талбай

Дээрх шинээр олгогдсон газруудын цэг солбоцол координатуудыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Сумын 2013 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний “Иргэний гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлэх газар” гэсэн хэгсгийн 2 дахь заалтад байгаа “Баянгийн 23-24 дүгээр хашааны дундуур” гэснийг “24-25 дугаар хашааны дундуур” болгон өөрчилсүгэй.

Гурав. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмж тусгасан саналыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжилт явцыг жилийн эцсийн ИТХ-ын хуралдаанд 2013 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хамт тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга /Д. Банзрагч/, газрын даамал /Д. Оргилбаяр/ нарт үүрэг болгосугай.

Дөрөв. Газрын тухай хууль болон түүнтэй холбогдон гаргасан хууль тогтоомжуудыг чанд мөрдөн ажиллаж хэрэгжилт, явц, үр дүнг сумын ИТХ-ын хуралдаанд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга Д. Банзрагч, байгаль орчны улсын байцаагч Ш. Нархүү, газрын даамал Д. Оргилбаяр нарт үүрэг болгосугай.

ÄÀÐÃÀ Á. Ï ¯ÐÝÂÑÝÍ ÃÝ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2013 оны 09 сарын 06 өдөр　　　　Дугаар _5/5_　　　　Хөвийн ам

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Ì î í ãî ë Óëñû í Çàñàã çàõèðãàà í óòàã äýâñãýðèéí í ýãæ ò¿¿í èé óäèðäëàãû í òóõàé õóóëèéí 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 124 дүгээр Тогтоол, Амгийн Засаг даргын 2013 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 120 дугаар Захирамжыг тус тус ¿í äýñëýí ñóì û í ÈÒÕ-û í ýýëæèò 5 äóãààð õóðàëäààí ààñ ÒÎ ÃÒÎ Î Õ í ü:

Сумын ИТХ-ын ээлжит 4 дүгээр хуралдааны 4/5 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтад “сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн нарийн бичгийн дарга /Х.Мядагбадам/” гэснийг “Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн ажилтан /Ч.Саранзаяа/” болгон өөрчилсүгэй.

ДАРГА　　　　　　Б. ПҮРЭВСЭНГЭ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2013 оны 09 сарын 05 өдөр Дугаар _5/6_ Хөвийн ам

Сумын хөгжлийн дунд хугацааны
зорилго, зорилт батлах тухай

Сумын эрхэм зорилго, үнэт зүйлс, дунд хугацааны зорилтыг боловсруулсан ажлын хэсгийн саналыг хэлэлцээд, Ì î í ãî ë Óëñû í Çàñàã çàõèðãààí óòàã äýâñãýðèéí í ýãæ ò¿¿í èé óäèðäëàãûí òóõàé õóóëèéí 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1.2–ын “е” дэх заалтыг тус тус ¿í äýñëýí ñóì ûí ÈÒÕ-ûí ýýëæèò 5 äóãààð õóðàëäààí ààñ ÒÎ ÃÒÎ Î Õ í ü:

Нэг. Сумын эрхэм зорилго, үнэт зүйлсийг 1 дүгээр хавсралтаар, дунд хугацааны зорилтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Сумын эрхэм зорилго, үнэт зүйлс, дунд хугацааны зорилтын дагуу төсөл хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлэхдээ олон нийтийн оролцоог ханган хөрөнгө оруулагч, иргэдийг хүчийг чиглүүлэн ажиллахыг сумын Засаг дарга /Д. Банзрагч/-д үүрэг болгосугай.

ДАРГА Б. ПҮРЭВСЭНГЭ

Сумын ИТХ-ын ээлжит 5 дугаар хуралдааны 5/6-р тогтоолын 1-р хавсралт

## *ГУРВАНБУЛАГ СУМЫН ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛ*

- Эцэг өвгөдийн сургааль – Өв уламжлал ёс заншлаа дээдлэнэ.
- Байгаль ээж шүтээн – Эх нутгаа хайрлаж, онгон байгалиа хамгаална.
- Миний Гурванбулаг – Эрүүл, сурч хөгжих, амар тайван орчинд ажиллаж амьдрахын төлөө
- Бүтээлч түмэн – Санаачлагатай хөдөлмөрч зан чанарыг бид илүү үнэлдэг
- Өрсөлдөх чадвар – Өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн үйлчилгээг хөгүүүлэх

____________оОо__________

Сумын ИТХ-ын ээлжит 5 дугаар хуралдааны 5/6-р тогтоолын 2-р хавсралт

## *ГУРВАНБУЛАГ СУМЫН ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТ /2013-2015/*

- 2014 онд багтаан баталгаатай, стандартын ундны усан хангамжтай болох
- Орон нутгийн давуу талд тулгуурлан жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, 2-оос доошгүй өөрийн брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээтэй болох
- Иргэдийн хөдөлмөрлөх, бизнес эрхлэх чадавхийг нэмэгдүүлэх
- 5 жилд багтаан сумын төвийг орчин үеийн тохилог хотхон болгох
- Малын үүлдэр угсааг сайжруулан 2017 он гэхэд сүргийн бүтцийн зохистой харьцаагаар 160000 / нэг зуун жаран мянга/-д хүргэх

____________оОо__________

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 09 сарын 06 өдөр | Дугаар _5/7_ | Хөвийн ам

Сумын Засаг дарга Д.Банзрагчид
зөвлөмж өгөх тухай

Монгол Ардын намын бүлгийн хэлэлцүүлэхээр оруулсан зохион байгуулалтын асуудлыг /Аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт, шинжилгээ, үнэлгээний хамтарсан багаас Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар, төсвийн байгууллагын үйл ажиллагаанд өгсөн шалгалтын зөвлөмжийн хэрэгжилтийг/ хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь: Сумын Засаг дарга Д. Банзрагч нь тус бичгийн хариуг өгсөн эсэх асуудал нь бүрхэг, хариулт тодорхойгүй байгаа нь учир дутагдалтай байгааг хэлэлцээд Ìîíãîë Óëñûí Çàñàã çàõèðãàà íóòàã äýâñãýðèéí íýãæ ò¿¿íèé óäèðäëàãûí òóõàé õóóëèéí 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг ¿íäýñëýí ñóìûí ÈÒÕ-ûí ýýëæèò 5 äóãààð õóðàëäààí ààñ ÒÎÃÒÎÎÕ íü:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт, шинжилгээ, үнэлгээний хамтарсан багаас Гурванбулаг сумын Засаг даргын тамгын газар, төсвийн байгууллагын үйл ажиллагаанд өгсөн шалгалтын зөвлөмжийн хэрэгжилтийг 9 дүгээр сарын 20-ны дотор гарган Монгол Ардын намын бүлэгт хүргүүлэхийг Засаг дарга Д. Банзрагчид даалгасугай.

Хоёр. Хуралдаанд төлөөлөгчдийн өгсөн санал, зөвлөмжийг цаашид хэрэгжүүлэх ажилдаа тусган ажиллахыг сумын Засаг дарга Д. Банзрагчид үүрэг болгосугай.

ДАРГА Б. ПҮРЭВСЭНГЭ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2013 оны 10 сарын 01 өдөр Дугаар _6/1_ Хөвийн ам

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт, Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалтуудыг үндэслэн сумын ИТХ-ын ээлжит бус 6 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Уул уурхайн асуудлыг шийдвэрлэх талаар сумын ИТХ-ын ээлжит бус 6 дугаар хуралдаанд иргэдийн гаргасан саналыг холбогдох дээд шатны байгууллага, албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгон баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д. Банзрагч /Сумын Засаг дарга/

Нарийн бичгийн дарга: Ц. Энхболд /Сумын ИТХ-ын төлөөлөгч/

Гишүүд: Ш. Нархүү /Байгал орчин хяналтын улсын байцаагч/

Ж. Шаравсэнгэ /Татварын улсын байцаагч/

С. Алтанчимэг /Эрүүл мэндийн төвийн дарга/

Б. Баяндалай /Багш/

Д. Цэцэгээ /Багш/

Д. Баяржаргал /Сургуулийн нийгмийн ажилтан/

Д. Эрдэнээ /2-р багийн Засаг дарга/

Э. Сайнбаяр /Нутгийн зөвлөлийн төлөөлөл/

М. Мягмарсүрэн /2-р багийн иргэн/

Н. Цэцэглэнжаргал /4-р багийн иргэн/

Д.Дашзэгвэ /5-р багийн иргэн/

З.Пүрэвжав /5-р багийн иргэн/

Б.Дашцоодол /5-р багийн иргэн/

Хоёр. Холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актуудыг мөрдлөг болгон ажиллаж хийсэн ажлын үр дүнг сумын ИТХ-ын хуралдаанд тайлагнаж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

Гурав. Дээрх ажлын хэсгийн үйл ажиллагаанд зарцуулах зардлыг Засаг даргын нөөц хөрөнгө, иргэд аж ахуй нэгж байгууллагуудын хандив тусламжаар санхүүжүүлсүгэй.

ДАРГА Б. ПҮРЭВСЭНГЭ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 19 өдөр Дугаар _7/1_ Хөвийн ам

Үндсэн чиглэлийн тухай

Сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2013 оны үндсэн чиглэлийн хэрэгжилт, 2014 оны үнсэн чиглэлийн тухай сумын Засаг дарга Д.Банзрагчийн илтгэлийг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “а” дахь заалтыг үндэслэн сумын ИТХ-ын ээлжит 7 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. 1. Сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2013 оны үндсэн чиглэлийн нийт 136 заалтаас 100 хувьтай хэрэгжсэн 49 заалт, 90 хувьтай хэрэгжсэн 18 заалт, 80 хувьтай хэрэгжсэн 24 заалт, 70 хувьтай хэрэгжсэн 15 заалт, 60 хувьтай хэрэгжсэн 6 заалт, 50 хувьтай хэрэгжсэн 12 заалт, 40 хувьтай хэрэгжсэн 1 заалт, 30 хувьтай хэрэгжсэн 2 заалт, 20 хувьтай хэрэгжсэн 1 заалт, огт хэрэгжээгүй 4 заалт, хүлээгдэж байгаа 4 заалт байгаа ба ерөнхий үнэлгээ 81 хувь байгаа учир биелэлтийг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2. Сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2014 оны үндсэн чиглэлд 2013 оны үндсэн чиглэлийн хэрэгжих шатандаа байгаа 4 заалтыг бүрэн хэрэгжүүлэх болон шинээр нэмэхээр Төлөөлөгчдийн гаргасан саналыг тусган 2014 оны үндсэн чиглэлийг баталсугай.

Хоёр. Үндсэн чиглэлийн заалтууд 2014 онд дэвшүүлсэн зорилтоо иргэдэд өргөнөөр сурталчилж хэрэгжилтийг хангах, иргэдийн идэвхтэй оролцоог нэмэгдүүлж ажиллан үр дүнг хагас, бүтэн жилээр ИТХ-ын хуралдаанд оруулж дүгнүүлэхийг сумын Засаг дарга /Д.Банзрагч/-д үүрэг болгосугай.

Гурав. Сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2014 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүйн чиглэл өгч ажиллахыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд даалгасугай.

ДАРГА Б. ПҮРЭВСЭНГЭ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2013 оны 12 сарын 20 өдөр Дугаар _7/2_ Хөвийн ам

Мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай

Сумын Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай сумын Засаг даргын орлогч Ч.Эрдэнэ-Очирын илтгэлийг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн “д” дэх заалтыг үндэслэн сумын ИТХ-ын ээлжит 7 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Сумын Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн эхний жилийн хэрэгжилт явцын тухай тавьсан тайлан илтгэлийг боловсруулалтын шаардлага хангахгүй байна гэж үзсүгэй.

Хоёр. Сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт явцыг Төлөөлөгчдийн тавьсан санал, зөвлөмжийн дагуу 2014 оны 1 дүгээр улирал багтаан сумын ИТХ-ын ээлжит бус хуралдаанд хэлэлцүүлж тайлагнахыг сумын Засаг дарга /Д.Банзүрагч/-д үүрэг болгосугай.

ДАРГА Б. ПҮРЭВСЭНГЭ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2013 оны 12 сарын 20 өдөр Дугаар _7/3_ Хөвийн ам

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх,
зарцуулах , хяналт тавих тухай

Сумын жижиг дунд үйлдвэрлэлийн сангийн зарцуулалтын талаар сумын нийгмийн хөгжлийн ажилтан Ч.Саранзаяагийн илтгэлийг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

2013 онд сум хөгжүүлэх сангийн жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр нийт 114.5 сая төгрөгийг 25 аж ахуйн нэгж, иргэнд сумын төсөл шалгаруулах орон тооны бус зөвлөлөөр хэлэлцүүлэн шалгаруулж олгосон ба тайлан илтгэлээс харахад зээлийг нэг ижил төрлийн олон төсөл, ажил үйлчилгээнд хэмжээг хэт багасган олгосон, зарим зээлийн мөн чанарыг алдагдуулан зориулалтын дагуу ашиглагдахгүй байх зэрэг дутагдалтай талууд ажиглагдаж байна. Мөн сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн дарга Д.Банзрагч өөрийн төрсөн дүүдээ зээл олгосон нь ашиг сонирхлын зөрчилтэй байгааг 2013 оны 11-р сарын 22-нд хийгдсэн аймгийн Хяналт, шинжилгээ үнэлгээний хамтарсан ажлын хэсгийн шалгалтаар тогтоогдон сум хөгжүүлэх санд буцаан төвлөрүүлэхээр шийдвэрлэгдсэн боловч одоо хүртэл эргэн төлөгдөөгүй байгаа зэрэг зөрчил дутагдал байгааг тэмдэглээд Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолыг үндэслэн сумын ИТХ-ын ээлжит 7 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Сум хөгжүүлэх сангийн 2014 оны зээлийн хүүгийн хэмжээг 3 /гурав/ хувиар тогтоосугай.

Хоёр. Сум хөгжүүлэх сангаас 2014 онд олгох зээлийн дээд хэмжээг 25000000 хорин таван сая/ төгрөг, доод хэмжээг 5000000 /таван сая/ төгрөг болгосугай.

Гурав. 1. Төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг 1-р хавсралтаар

2. Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг 2 дугаар хавсралтаар тус тус сонгон баталсугай.

Дөрөв. Сумын Засаг дарга Д.Банзрагчид үүрэг болгох нь:

1. Сангийн үйл ажиллагааны үр дүнг жил бүр сумын ИТХ-ын хуралдаанд тайлагнаж ажилласугай.

2. Аймгийн Хяналт шинжилгээ, үнэлгээний хамтарсан ажлын хэсгээс ашиг сонирхлын зөрчилтэйгээр олгогдсон нь тогтоогдсон 11000000 /арван нэгэн сая/ төгрөгийн зээлийг 2014 оны эхний хагас жилд багтаан сум хөгжүүлэх санд эргэн төвлөрүүлсүгэй.

Тав. Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтын дүнг жил бүрийн ИТХ-ын хуралдаанд танилцуулж ажиллахыг хяналтын зөвлөлд үүрэг болгосугай.

Зургаа. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан сумын ИТХ-ын 2013 оны 4/5, 5/5 тоот тогтоолуудыг тус тус хүчингүй болгосугай.

ДАРГА Б. ПҮРЭВСЭНГЭ

Сумын ИТХ-ын ээлжит 7 дугаар хуралдааны 7/3 дугаар тоот тогтоолын 1 дүгээр хавсралт

## СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛ

Дарга Сумын Засаг дарга /Д.Банзрагч/

Нарийн бичгийн дарга Сумын Нийгмийн хөгжлийн бодлогын ажилтан /Ч.Саранзаяа/

Гишүүд: Төрийн сангийн төлөөлөгч /П.Тогтохжаргал/
Төрийн банкны эрхлэгч /Р.Сосорбурам/
Хаан банкны эрхлэгч /Ч.Батцэцэг/
Төлөөлөгч /Д.Болд-Аюуш/
Төлөөлегч /Д.Энхээ/

__________оОо__________

Сумын ИТХ-ын ээлжит 7 дугаар хуралдааны 7/3 дугаар тоот тогтоолын 2 дугаар хавсралт

## СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ЗЭЭЛИЙН АШИГЛАЛТ, ЭРГЭН ТӨЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТАД ХЯНАЛТ ТАВИХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛ

Ахлагч: Сумын ИТХ-ын Төлөөлөгч Д.Баяржаргал

Нарийн бичиг: ИТХ-ын Төлөөлөгч Р.Цогт

Гишүүд: ИТХ-ын Тэргүүлэгч Ц.Баатаржав
ИТХ-ын Тэргүүлэгч Э.Жавхлан
ИТХ-ын Тэргүүлэгч Ц.Энхболд
ИТХ-ын Тэргүүлэгч Д.Энхээ
ИТХ-ын Тэргүүлэгч Ч.Эрдэнэ-очир

___________оОо___________

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2013 оны 12 сарын 20 өдөр Дугаар _7/4_ Хөвийн ам

Төсөвт тодотгол хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “б” дэх заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 64.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын ээлжит 7 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Сумын 2013 оны орон нутгийн орлогын эхний үлдэгдэл 4000.0 мянган төгрөгийг ЗДТГ-ын орон нутгийн нөөц хөрөнгөнд, орон нутгийн орлогоос 1400.0 төгрөгийг багийн цалингийн санд тус тус нэмж хуваарилсугай.

Хоёр. Улсын нэгдсэн төсөв болон аймгийн төсөвт тодотгол хийсэнтэй уялдуулж сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах байдлаар хуваарилсугай.

| Д/Д | Хөрөнгө оруулалтын нэр | Дүн / мянган төгрөгөөр/ |
|---|---|---|
| 1 | Наадмын зардал | 5000.0 |
| 2 | Малжуулах /15 өрх тус бүр 70 мал/ | 63000.0 |
| 3 | Тамгын газрын зураг төсвийн үнэ | 7100.0 |
| 4 | Иргэний танхим байгуулах тавилга тоног | 14000.0 |
| 5 | Багийн төв шинээр барих /Давааны ам баг/ | 35000.0 |
| 6 | Сумын ерөнхий төлөвлөгөө хийлгэх | 19000.0 |
| 7 | Шугам сүлжээний өргөтгөл | 11400.0 |
| 8 | Гудамжны гэрэлтүүлэг хийх | 18900.0 |
| 9 | Малын үүлдэр угсаа сайжруулах зардал | 5926.0 |
| 10 | Тэжээлийн агуулахын засвар | 5000.0 |
| 11 | Булгийн эх хамгаалах /Нарийний рашаан/ | 5000.0 |
| 12 | Булгийн эх хамгаалах /Хужирт толгой/ | 5000.0 |
| 13 | Хогны, усны авто машины урсгал засвар | 2520.0 |
| 14 | Халуун усны зураг төсвийн үнэ | 4245.1 |
| 15 | Морин мөрт худгийн мотор худалдан авах | 2000.0 |
| 16 | Тэжээлийн агуулах барих /Буга баг/ | 4000.0 |
| 17 | Тэжээлийн агуулах барих /Давааны ам баг/ | 5174.5 |
| 18 | Багийн төв шинээр барих /Хөвийн ам баг/ | 38000.0 |
| 19 | Гамшигаас хамгаалах тэжээлийн нөөц | 5560.0 |
| | **Нийт дүн** | **255825.6** |

Дээрх орлогыг зориулалтын дагуу зарцуулахыг Тамгын газрын ерөнхий менежер Б. Цэдэндамба, Төрийн сангийн төлөөлөгч П. Тогтохжаргал нарт үүрэг болгосугай.

Дээрх тогтоол батлагдсантай холбогдуулан 2013 оны 5/3 тоот тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА Б. ПҮРЭВСЭНГЭ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2013 оны 12 сарын 20 өдөр Дугаар _7/5_ Хөвийн ам

Сумын 2014 оны төсөв батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, аймгийн ИТХ-ын 2013 оны 6/2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Гурванбулаг сумын 2014 оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

| | |
|---|---|
| **Сумын төсвийн орлого бүгд** | **93500.0** |
| **Нэг. Орон нутгийн орлого** | **89100.0** |
| **1. Хүн амын орлого** | **84450.0** |
| а. Цалин хөлс түүнтэй адилтгах /суутган 1/ | 75850.0 |
| б. Иргэний орлого тодорхойлох хуудсаар | 8000.0 |
| в. Патент | 600.0 |
| **2. АТӨЯХ-ийн татвар** | **4400.0** |
| 3. **Үл хөдлөх хөрөнгө** | **300.0** |
| **4. Бууны татвар** | **700.0** |
| **5. Нохойны албан татвар** | **300.0** |
| **6. Бусад төлбөр хураамж** | **1100.0** |
| а. Улсын тэмдэгтийн хураамж | 700.0 |
| б. Газрын төлбөр | 300.0 |
| в. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 100.0 |
| **7. Хүү торгууль** | **1500.0** |
| **2. Төсөвт байгууллагын өөрийн орлого** | **750.0** |
| **Хоёр. Тусламжийн орлого** | **1597384.1** |
| 2.1. Санхүүгийн дэмжпэг | 204829,8 |
| 2.2. Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг | 343128,1 |
| 2.3. Тусгай зориулалтын шилжүүлэг | 1049426.2 |

Хоёр. Сумын 2014 оны төсвийн жилд ерөнхийлөн захирагч, түүний харъяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

/Мянган төгрөг/

| | | |
|---|---|---|
| **2.1** | **9 жилийн дунд сургууль** | **200.0** |
| **2.2** | **Соёлын төв** | **1054.0** |

Гурав. Сумын 2014 оны нутгийн төсвийн зарлагын нийт дүн, төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн жилд зарцуулах зарлагын дээд хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

/Мянган төгрөг/

| | | |
|---|---|---|
| **3.1** | **Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга** | **56722.5** |
| **3.2** | **ЗДТГ** | **184853.8** |
| **3.3** | **Баг** | **52353.5** |

Дөрөв. Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих төсөвт байгууллагын зардлын хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

/Мянган төгрөг/

| | | |
|---|---|---|
| **4.1** | **9-н жилийн дунд сургууль** | **544591.3** |
| **4.2** | **Эрүүл мэндийн төв** | **270581.1** |
| **4.3** | **Цэнгэл цэцэрлэг** | **192715.8** |
| **4.4** | **Соёлын төв** | **41538.0** |

Тав. Сумын ИТХ-ын төсвийн хуваарийг 1 дүгээр хавсралтаар, ЗДТГ-ын төсвийн хуваарийг 2 дугаар хавсралтаар, багийн төсвийн хуваарийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Зургаа. Сумын хөрөнгө оруулалт, их засварын нэр төрөл, төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг 4 дүгээр хавсралт ёсоор баталсугай.

Долоо. Батлагдсан төсвөө үр ашигтай зарцуулж ажиллахыг төсөв захирагч нарт, төсвийн зарцуулалтыг хагас бүтэн жилээр дүгнэн сумын ИТХ-ын хуралдаанд тайлагнахыг төсвийн ерөнхийлөн захирагч /Сумын Засаг дарга/-д үүрэг болгосугай.

ДАРГА Б. ПҮРЭВСЭНГЭ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 27 өдөр Дугаар _7/6_ Хөвийн ам

Ой зохион байгуулах ажлын хэсэг
байгуулах тухай

Сумын Засаг дарга Д.Банзрагчийн хэлэлцүүлсэн сумын түүхт 90 жилийн ойн бэлтгэл ажлыг хангах ажлын хэсэг байгуулах саналыг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25.1 дэх заалтыг үндэслэн сумын ИТХ-ын ээлжит 7 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Сумын түүхт 90 жилийн ой зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Ойн бэлтгэл ажлыг хангах ажлын төлөвлөгөө боловсруулж, ойд аж ахуйн нэгж байгууллага иргэдийг өргөнөөр хамруулах ажлыг зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга Б.Пүрэвсэнгэ, орлогч дарга Д.Банзрагч нарт үүрэг болгосугай.

ДАРГА Б. ПҮРЭВСЭНГЭ

Сумын ИТХ-ын ээлжит 7 дугаар хуралдааны 7/6 тоот
тогтоолын хавсралт

СУМЫН ТҮҮХТ 90 ЖИЛИЙН ОЙГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга Б.Пүрэвсэнгэ - Сумын ИТХ-ын дарга

Орлогч дарга Д.Банзрагч - Сумын Засаг дарга

Нарийн бичгийн дарга - Б.Цэдэндамба - ЗДТГ-ын дарга

Гишүүд: Ч.Эрдэнэ-Очир - Сумын Засаг даргын орлогч

Р.Гантулга - Ерөнхий боловсролын сургуулийн захирал

С.Алтанчимэг - Эрүүл мэндийн төвийн дарга

Д.Мөнхжаргал - Соёлын төвийн эрхлэгч

Ч.Бямбасүрэн - Цэнгэл цэцэрлэгийн эрхлэгч

Ц.Баатаржав - ИТХ-ын тэргүүлэгч

Н.Оюумаа - ИТХ-ын тэргүүлэгч

Э.Жавхлан - ИТХ-ын тэргүүлэгч

Б.Баяндалай - ИТХ-ын тэргүүлэгч

Д.Баяржаргал - ИТХ-ын тэргүүлэгч

Г.Ууганбаяр - ИТХ-ын тэргүүлэгч

П.Тогтохжаргал - Төрийн сангийн төлөөлөгч

Р.Ганболд - Засагдаргын зөвлөлийн гишүүн

Ж.Чулуунбат - Засагдаргын зөвлөлийн гишүүн

Д.Уранчимэг - Тамгын газрын нягтлан бодогч

Э.Батзориг - Хэсгийн төлөөлөгч

Ц.Баатаржав – 1-р багийн Засаг дарга

Д.Эрдэнээ – 2-р багийн Засаг дарга

Д.Болд-Аюуш – 3-р багийн Засагдарга

Ж.Бадрал – 4-р багийн Засаг дарга

Д.Дагважамц - 5-р багийн Засаг дарга

Ж.Шаравсэнгэ - Уяачдын холбооны тэргүүн

Л.Цэдэнсодном - Бөхийн холбооны тэргүүн

Д.Эрдэнэсайхан - Шагайн холбооны тэргүүн

Ц.Оюунтуяа - Бизнесмэний холбооны тэргүүн

Л.Бямбасүрэн - Ахмадын холбооны дарга

Д.Дашзэгвэ - Өндөр настан

М.Тангад - Өндөр настан

Ч.Батцэцэг - ХААН банкны эрхлэгч

**_______оОо_______**

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 27 өдөр Дугаар _7/7_ Хөвийн ам

Төсөвт тодотгол хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж тууний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 1.2-ын "б" дэх заалт, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын ээлжит 7 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. 2013 оны сумын ЗДТГ-ын харилцахын эхний үлдэгдэл 4060430 /дөрвөн сая жаран мянга дөрвөн зуун гучин/ төгрөг, орон нутгийн ерөнхий орлогын дансны эхний үлдэгдэл 1095400 /нэг сая ерэн таван мянга дөрвөн зуун/ төгрөгийг ЗДТГ-ын нөөц хөрөнгөнд нэмж хуваарилсугай.

Хоёр. Дээрх зардалыг зориулалтын дагуу зарцуулахыг ЗДТГ-ын дарга, төрийн згийн төлөөлөгч, нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.

ДАРГА Б. ПҮРЭВСЭНГЭ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 27 өдөр Дугаар _7/7_ Хөвийн ам

Төсөвт тодотгол хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж тууний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 1.2-ын "б" дэх заалт, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын ээлжит 7 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. 2013 оны сумын ЗДТГ-ын харилцахын эхний үлдэгдэл 4060430 /дөрвөн сая жаран мянга дөрвөн зуун гучин/ төгрөг, орон нутгийн ерөнхий орлогын дансны эхний үлдэгдэл 1095400 /нэг сая ерэн таван мянга дөрвөн зуун/ төгрөгийг ЗДТГ-ын нөөц хөрөнгөнд нэмж хуваарилсугай.

Хоёр. Дээрх зардалыг зориулалтын дагуу зарцуулахыг ЗДТГ-ын дарга, төрийн знгийн төлөөлөгч, нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.

ДАРГА Б. ПҮРЭВСЭНГЭ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014 оны 06 сарын 02 өдөр Дугаар _7/8_ Хөвийн ам

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “з” дэх заалтыг үндэслэн сумын ИТХ-ын ээлжит 7 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын 2014 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд төлөөлөгчдийн гаргасан саналыг нэмж тусган хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжилтийг жилийн эцсийн ИТХ-ын хуралдаанд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга, газрын даамал нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Сумын ИТХ-ын 2013 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 4/4 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА Б. ПҮРЭВСЭНГЭ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 06 сарын 02 өдөр Дугаар _7/9_ Хөвийн ам

2014 оны орон нутгийн хөгжлийн санд
тодотгол хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.12 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалтын үндэслэн сумын ИТХ-ын ээлжит 7 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээг 1 дүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу зарцуулан, хэрэгжилтийг ханган ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч /Сумын Засаг дарга/, төсвийн шууд захирагч /ЗДТГ-ын дарга/, нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Сумын ИТХ-ын 2013-оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 7/5 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг хүчингүй болгосугай.

ДАРГА Б. ПҮРЭВСЭНГЭ

Сумын ИТХ-ын 2014.06.02-ны өдрийн 7/9 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

# ГУРВАНБУЛАГ СУМЫН 2014 ОНД ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГААР ХИЙГДЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОДОТГОЛ

2014 оны 06 дугаар сарын 02
Пионер толгой

| № | Төсөл арга хэмжээний нэр | Тодотгосон төсөв |
|---|---|---|
| 1 | 3-р багийн төвийн засвар | 5725 |
| 2 | 3-р баг нэмэлт | 572 |
| 3 | 1,4-р багийг гаднах хайс | 6000 |
| 4 | Гудамж талбайн камержуулапт | 16000 |
| 5 | Халуун усны барилга барих | 25000 |
| 6 | Малжуулах | 28000 |
| 7 | 4-р баг тэжээлийн агуулах | 5700 |
| 8 | 1-р багийн тэжээлийн агуулах | 6000 |
| 9 | Наадмын зардал | 5000 |
| 10 | Наадмын талбайн засвар | 20000 |
| 11 | Ахуй үйлчилгээний барилга засварлах | 40886 |
| 12 | Давааны ам багийг эрчим хүчинд холбох | 9900 |
| 13 | Хүүхэд залуучуудын парк | 20000 |
| 14 | Сургуулийн шалны засвар | 27149 |
| 15 | Физик эмчилгээний аппарат | 11350 |
| 16 | Соёлын төвийн сандал | 6000 |
| 17 | 4 ширхэг чанга яригч авах | 1500 |
| 18 | Байгууллагын гадна тохижилт | |
| 19 | Сургууль | 9800 |
| | ЗДТГ | 9900 |
| | ЭМТ | 9800 |
| | Соёлын төв | 1803.6 |
| 20 | Гамшгаас хамгаалах нөөц | 5435 |
| 21 | Жаргалант хөндийн худгыг эрчим хүчинд холбох | 33365 |
| 22 | Цагдаагийн кабон, машины засвар | 13034.7 |
| 23 | 4-р багийн төвийн барилга | 21800 |
| 24 | Спорт заалны гэрэлтүүлэг | 1800 |
| 25 | Спорт хэрэглэгдэхүүн | 1607.8 |
| | Дүн | 343128.1 |

_________оОо_________

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014 оны 10 сарын 06 өдөр Дугаар _8/1_ Хөвийн ам

Дэмжлэг үзүүлэх тухай

Тус сумын 1-р багийн иргэн Өөдөс, 3 дугаар багийн иргэн П.Түвшинтөгс, 4 дүгээр багийн иргэн Улаанхүү, Баянзул, 5-р багийн иргэн Ж.Ханд, Ц.Баатаржав нар “Жи Энд Юу Гоулд” ХХК-аас тус сумын нутаг дэвсгэр, байгаль орчинд учруулсан хохирол нэхэмжлэх, тусгай зөвшөөрлийг цуцлуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Тэд өөрсдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр “Дэлхийн Монгол ногоон нэгдэл” төрийн бус байгууллага /Тэргүүн Х.Бээжин/, “Босоо Хөх Монгол” төрийн бус байгууллага /Тэргүүн Э.Төмөрхуяг/ нарыг оролцуулахаар шийдвэрлэсэн ба өмгөөлөгчийн хөлсөнд дэмжлэг хүссэнийг тэмдэглээд Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын ээлжит бус 8 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Дээрх үйл ажиллагаатай холбогдон гаргах зардалыг Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлд шийдвэрлүүлэх талаар санал уламжлахыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

Хоёр. Тус зардлыг бүрдүүлэхэд хандив өгөхийг нийт иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй, нэгжүүдэд уриалсугай.

ДАРГА Б. ПҮРЭВСЭНГЭ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014 оны 10 сарын 06 өдөр Дугаар _8/2_ Хөвийн ам

Үйл ажиллагаа зогсоох тухай

Тус сумын нутагт ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа “Жи Энд Юу Гоулд” ХХК нь Ашигт малтмалын тухай хуулийн 35.4 дэх “Геологи уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон комисс уурхайг хүлээн авсны дараа ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг уурхайг ажиллуулж эхэлнэ”, Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх заалтыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын ээлжит бус 8 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. “Жи-Энд-Юу-Гоулд” ХХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Өвөр хөшөөтийн 12806А талбайд ашиглалтын үйл ажиллагаа явуулахыг хориглосугай.

Хоёр. Тогтоолын хэрэгжилт, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавьж хуулийг хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга Д.Банзрагчид үүрэг болгосугай.

ДАРГА Б.ПҮРЭВСЭНГЭ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014 оны 12 сарын 22 өдөр Дугаар _9/1_ Хөвийн ам

⌐ ¯í äñýí ÷èãæýëèéí òóõàé ¬

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “а” дахь заалтыг үндэслэн сумын ИТХ-ын ээлжит 9 дүгээр хуралдаанаас ТОГТООХ í ü:

Ñóì ûí ýäèéí çàñàã íèéãì èéã õº ãæ¿¿ëýõ 2014 îíû ¿í äñýí ÷èãëýëèéí íèéò 108 çààëòààñ 100 õóâьтай õýðýãæñýí 60 çààëò, 90 õóâьтай õýðýãæñýí 9 çààëò, 80 õóâьтай õýðýãæñýí 17 çààëò, 70 õóâьтай õýðýãæñýí 1 çààëò, 60 õóâьтай õýðýãæñýí 2 çààëò, 50 õóâьтай õýðýãæñýí 6 çààëò, 20 õóâтай õýðýãæñýí 2 çààëò, îãò õýðýãæýýã¿é çààëò 1, хүлээгдэж буй 8 заалт, хамааралгүй 2 заалт áàéãàà нь “85” õóâийн биелэлттэй ерөнхий үнэлгээ 4.3 байгаа тул биелэлтийг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

ÄÀÐÃÀ Á.Ï ¯ÐÝÂÑÝÍ ÃÝ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 23 өдөр Дугаар _9/2_ Хөвийн ам

┌ ┐
¯í äñýí ÷èãëýë батлах òóõàé

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “а” дахь заалтыг үндэслэн сумын ИТХ-ын ээлжит 9 дүгээр хуралдаанаас ТОГТООХ í ü:

Сумын Эдийн засаг нийгмийн 2015 оны үндсэн чиглэлийг 13 бүлэг 124 заалттайгаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, төлөөлөгчдийн гаргасан саналуудыг нэмж тусган хавсралтаар баталсугай.

Үндсэн чиглэлийн заалтууд 2015 онд дэвшүүлсэн зорилтоо иргэдэд өргөн сурталчилж хэрэгжилтийг хангах, иргэдийн идэвхитэй оролцоог нэмэгдүүлж, ажиллан үр дүнг хагас, бүтэн жилээр ИТХ-ын хуралдаанд оруулж дүгнүүлэхийг сумын Засаг дарга Д.Банзрагчид үүрэг болгосугай.

Сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2015 оны үí äñýí ÷èãëýëийн хэрэгжилтэд хяналт тавин зохион байгуулалт, арга зүйн зөвлөмж чиглэл өгч ажиллахыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ÄÀÐÃÀ Á.Ï ¯ÐÝÂÑÝÍ ÃÝ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 23 өдөр Дугаар _9/3_ Хөвийн ам

Засаг даргын мөрийн хөтөлбөрийн
хэрэгжилтийн тухай

Сумын Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн эхний хоёр жилийн хэрэгжилтийн тухай сумын Засаг даргын орлогч Ч.Эрдэнэ-Очирын илтгэлийг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1.1-ын "д" дэхь заалтыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын ээлжит 9 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн нийт 169 заалтаас хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа 147 заалт, хүлээгдэж буй 22 заалт байгаа нь эхний хоёр жилийн хэрэгжилт 70 хувьтай байгаа ба үлдсэн хугацаатай харьцуулахад хэрэгжилтийг "Хангалттай" гэж дүгнэсүгэй.

2. Үлдсэн хугацаанд хэрэгжих шатандаа байгаа болон хүлээгдэж буй заалтуудыг хэрэгжүүлэх ажилд төлөөлөгчдийн гаргасан саналуудыг нэмж тусган хэрэгжилтийг зохион байгуулж сумын ИТХ-ын хуралдаанд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга Д.Банзрагчид үүрэг болгосугай.

ДАРГА Б.ПҮРЭВСЭНГЭ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014 оны 12 сарын 24 өдөр Дугаар _9/6_ Хөвийн ам

Сумын 2014 оны төсөв тодотгол хийх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх заалт, аймгийн ИТХ-ын 2014 оны 12/2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сумын Засаг даргын Тамгын газрын төсвийг 646200 төгрөгөөр , багийн төсвийг 413500 төгрөгөөр, ИТХ-ын төсвийг 1499300 төгрөгөөр тус тус хасч тодотгосугай.

2. Багийн төсвөөс 1412700 төгрөгийг ЗДТГ-ын төсөв дээр нэмж тодотгон баталсугай.

3. Сумын орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгийг хавсралтаар тодотгон баталсугай.

4. Орон нутгийн хөгжлийн сангийн төслөөр 2014 онд хэрэгжсэн ажлуудаас дутуу байгаа ажлуудыг гүйцээлгэх арга хэмжээ авч ажиллахыг сумын Засаг даргад үүрэг болгосугай.

5. Тодотгосон төсвөө үр ашигтай зарцуулж, тайлагнан ажиллахыг төсөв захирагч нарт үүрэг болгосугай.

6. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Сумын ИТХ-ын 2014 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 7/9 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА Б. ПҮРЭВСЭНГЭ

Сумын ИТХ-ын 2014 оны 12 дугаар сарын 24-ний
өдрийн 9/6 дугаар тогтоолын хавсралт

# СУМЫН 2014 ОНД ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОДОТГОЛ

| Д/Д | Төслийн нэр | тодотгосон төсөв /мян.төг/ |
|---|---|---|
| 1 | 3-р багийн төвийн засвар | 5725 |
| 2 | 3-р багийн төвийн засвар нэмэлтээр | 570 |
| 3 | 1, 4-р багийн гаднах хайс | 6000 |
| 4 | Гудамж талбайн камержуулалт | 16000 |
| 5 | 4-р багийн тэжээлийн агуулах | 5700 |
| 6 | Халуун усны барилга барих | 25000 |
| 7 | 1-р багийн тэжээлийн агуулах барих | 6000 |
| 8 | Малжуулах | 28000 |
| 9 | Наадмын зардал | 5000 |
| 10 | Наадмын талбайн засвар | 20000 |
| 11 | Ахуй үйлчилгээний барилга засварлах | 35886 |
| 12 | Давааны ам багийг эрчим хүчинд холбох | 9900 |
| 13 | Гамшгаас хамгаалах нөөц бүрдүүлэх | 5435 |
| 14 | Хүүхэд залуучуудын парк | 20000 |
| 15 | Сургуулийн шалны засвар хийх | 27149 |
| 16 | Физик эмчилгээний аппарад худалдан авах | 9294.2 |
| 17 | Соёлын төвд сандал худалдан авах | 6000 |
| 18 | 4 ширхэг чанга яригч авах | 1500 |
| 19 | Сургуулийн засвар | 9800 |
| 20 | ЗДТГ-ын засвар | 9900 |
| 21 | Соёлын төвийн засвар | 1803.6 |
| 22 | ЭМТ-ийн засвар | 9800 |
| 23 | Цагдаагийн кабон, машины засвар | 13034.7 |
| 24 | Спорт заалны гэрэлтүүлэг | 1800 |
| 25 | 1-р багийн төв барих | 35000 |
| 26 | Сумын төвийн интернетэд холбох /урьдчилгаа төлбөр/ | 5000 |
| | Дүн | 319297.5 |

______оОо_____

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014 оны 12 сарын 24 өдөр Дугаар _9/7_ Хөвийн ам

Сумын 2015 оны төсөв батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, аймгийн ИТХ-ын 2014 оны 11/1 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. сумын 2015 оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурдсанаар баталсугай.

| | |
|---|---|
| **Сумын төсвийн орлого бүгд** | **13500.0** |
| **Нэг. Орон нутгийн орлого** | **13500.0** |
| а. Иргэний орлого тодорхойлох хуудсаар | 9000.0 |
| б. Патент | 600.0 |
| В. Бууны татвар | 700.0 |
| **1. Бусад төлбөр хураамж** | **1100.0** |
| а. Улсын тэмдэгтийн хураамж | 700.0 |
| б. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 100.0 |
| в.Нохойны албан татвар | 300.0 |
| **2. Хүү торгууль** | **1500.0** |
| **2. Төсөвт байгууллагын өөрийн орлого** | **600.0** |
| **Хоёр. Тусламжийн орлого** | **1579838.1** |
| 2.1. Санхүүгийн дэмжлэг | 283695.5 |
| 2.2. Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг | 270640.0 |
| 2.3. Тусгай зориулалтын шилжүүлэг | 1025502.6 |

Хоёр. Сумын 2015 оны төсвийн жилд ерөнхийлөн захирагч, түүний харъяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

/Мянган төгрөг/

| | | |
|---|---|---|
| **2.1** | **9 жилийн дунд сургууль** | **200.0** |
| **2.2** | **Соёлын төв** | **1000.0** |

Гурав. Сумын 2015 оны нутгийн төсвийн зарлагын нийт дүн, төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн жилд зарцуулах зарлагын дээд хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

/Мянган төгрөг/

| | | |
|---|---|---|
| **3.1** | **Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга** | **45335.0** |
| **3.2** | **ЗДТГ** | **195126.9** |
| **3.3** | **Баг** | **56733.5** |

Дөрөв. Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих төсөвт байгууллагын зардлын хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

/Мянган төгрөг/

| | | |
|---|---|---|
| **4.1** | **9-н жилийн дунд сургууль** | **507475.0** |
| **4.2** | **Эрүүл мэндийн төв** | **270510.9** |
| **4.3** | **Цэнгэл цэцэрлэг** | **203896.7** |
| **4.4** | **Соёлын төв** | **43620.0** |

Тав. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх хөрөнгө оруулалт, их засварын нэр төрөл, төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг 1 дүгээр хавсралт ёсоор баталсугай.

Зургаа. Батлагдсан төсвөө үр ашигтай зарцуулж ажиллахыг төсөв захирагч нарт, төсвийн зарцуулалтыг хагас бүтэн жилээр дүгнэн сумын ИТХ-ын хуралдаанд тайлагнахыг төсвийн ерөнхийлөн захирагч /Сумын Засаг дарга/-д үүрэг болгосугай.

ДАРГА Б. ПҮРЭВСЭНГЭ

Сумын ИТХ-ын 2014 оны 12 дугаар сарын  24-нйй
өдрийн 9/7 дугаар тогтоолын хавсралт

СУМЫН 2015 ОНД ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН
ХӨРӨНГӨӨР ХИЙГДЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/Д | Төслийн нэр | Төсөвт өртөг Мянган төгрөгөөр |
|---|---|---|
| 1 | Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний үнийн зөрүү | 5.700 |
| 2 | Сумын төвийг интернет сүлжээнд холбох | 20.000 |
| 3 | Жаргалант хөндийн худгийг эрчим хүчинд холбох | 33.300 |
| 4 | Малжуулах /5 өрх/ | 28.000 |
| 5 | Цэнгэл багийн төвийг зөөж барих /морин мөрт/ | 20.000 |
| 6 | Дотуур байранд их засвар ажлын зөрүү хийх | 30.000 |
| 7 | Хог, усны машины засвар | 5.600 |
| 8 | Гамшгаас хамгаалах нөөц бүрдүүлэх | 9.000 |
| 9 | Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах /2 хөшөө/ | 2.000 |
| 10 | Халуун усны барилга барих | 25.000 |
| 11 | Гар худаг сэргээн засварлах | 4.000 |
| 12 | Бэлчээр хамгаалах | 10.000 |
| 13 | Хүний хөгжлийг хангах | 9.700 |
| 14 | Спорт заалны дээврийн засврын зөрүү | 15.000 |
| 15 | Багуудын дотоод тохижилт | 8.000 |
| 16 | Наадмын зардал | 5.000 |
| 17 | Иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах | 9.900 |
| 18 | Яаралтай тусламжийн өрөө тохижуулах | 5.500 |
| 19 | Яаралтай тусламжийн тоног төхөөрөмж худалдан авах | 9.800 |
| 20 | Насан туршийн боловсролын төвийг тохижуулах | 5.100 |
| 21 | 3-р багийн тэжээлийн агуулах засварлах | 2.000 |
| 22 | Эрчим хүчний өргөлтгөлийн зураг, төсөв хийлгэх | 1.000 |
| 23 | Ховордсон ан амьтан, ургамалын тооллого хийх | 2.000 |
| 24 | Хууль зүйн туслалцаа авах /өмгөөлөгчийн зардал/ | 5.000 |
| Дүн | | 270.600 |

_________оОо________

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014 оны 12 сарын 24 өдөр Дугаар _9/8_ Хөвийн ам

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг үндэслэн ñóì û í ÈÒÕ-û í ýýëæèò 9 äүгээð õóðàëäààí ààñ ÒÎ ÃÒÎ Î Õ í ü:

1. Уул уурхайн талаарх мэдээлэл цуглуулах, бодит байдлыг үнэлэх иргэдийн төлөөлөгчдийн хурлыг үнэн зөв мэдээллээр хангах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч - Э.Жавхлан ИТХ-ын тэргүүлэгч, төлөөлөгч

Гишүүд Б.Баяндалай - ИТХ-ын тэргүүлэгч, төлөөлөгч

Ц.Энхболд - ИТХ-ын тэргүүлэгч, төлөөлөгч

Ж. Чулуунбат - ИТХ-ын төлөөлөгч

Р.Ганболд - ИТХ-ын төлөөлөгч

2. Уул уурхайн талаарх мэдээлэл цуглуулах, бодит байдлыг үнэлэх ажлыг зохион байгуулж 2015 оны 1 дүгээр улиралд багтаан сумын ИТХ-ын хуралдаанд тайлагнахыг ажлын хэсэгт үүрэгболгосугай.

3. Дээрх ажлын хэсгийн үйл ажиллагаанд зарцуулагдах зардлыг сумын иргэд, төсвийн албан байгууллагуудын дэмжлэгээр санхүүжүүлсүгэй.

ДАРГА Б.ПҮРЭВСЭНГЭ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 24 өдөр　　　　Дугаар _9/9_　　　　Хөвийн ам

┌　　　　　　　　┐
Ñóì õº ãæ¿¿ëýõ ñàí ãèéí õº ðº í ãèéãá¿ðä¿¿ëýõ,
çàðöóóëàõ, õÿí àëò òàâèõ æóðì ûí
хэрэгжилтийн òóõàé

Сумын жижиг дунд үйлдвэрлэлийн сангийн зарцуулалтын талаар нийгмийн хөгжлийн ажилтан Ч. Саранзаяагийн тайланг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Ì î í ãî ë Óëñûí Çàñãèéí Ãàçðûí 2011 î í û 134 ä¿ãýýð òî ãòî î ëûã тус тус ¿í äýñëýí ñóì ûí ÈÒÕ-ûí ýýëæèò 9 äүгээð õóðàëäààí ààñ ÒÎ ÃÒÎ Î Õ í ü:

1. Ñóì õº ãæ¿¿ëýõ ñàí ãèéí 2015 î í û çýýëèéí õ¿¿ãèéí õýì æýýã 3 /гурав/ õóâèàð шинэчлэн òî ãòî î ñóãàé.

2. Ñóì õº ãæ¿¿ëýõ ñàí ãààñ 2015 î í ä í ýã çýýëä î ëãî õ äýýä õýì æýýã 25000000 /Хорин таван сая/ доод хэмжээг 3 сая болгон шинэчлэн тогтоосугай.

3. Олгогдсон зээлийн хүүгийн орлогоос 1 сая /нэг сая/ төгрөгийг “Төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл, õөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад õÿí àëò тавих чиг үүрэг бүхий орон тооны бус çөâëөëийн үйл ажиллагаанд зарцуулахыг зөвшөөрсүгэй.

ÄÀÐÃÀ　　　　　　　Á.Ï ¯ÐÝÂÑÝÍ ÃÝ